



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ 2024 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА **ЕРӨӨ СУМЫН
ЗАСАГ ДАРГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Гэрээний зорилго нь Сэлэнгэ аймгийн Засаг даргаас **Ерөө** сумын Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах ажил, арга хэмжээ түүнд тохирсон санхүүжилт, талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, эцсийн үр дүнг үнэлж, дүгнэх замаар төсвийн санхүүжилтээр үзүүлэх төрийн болон нийгмийн салбарын суурь үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэхэд оршино.

1.2.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.1.1, 7.1.6, 7.1.7, 7.1.8, 40 дүгээр зүйлийн 40.1, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 6, 7, 8 дугаар зүйл Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.2.1, 57 дугаар зүйлийн 57.1, Иргэний хуулийн 195-205 дахь зүйлүүдийг тус тус үндэслэн энэхүү гэрээг нэг талаас **Сэлэнгэ аймгийн Засаг дарга Нацагдоржийн Лхагвадорж**, нөгөө талаас **Ерөө сумын Засаг дарга Батмөнхийн Сэргэлэн** нар 2024 оны 01-р сарын 02-ны өдрөөс 2024 оны 12-р сарын 31-ний өдрийг дуустал буюу нэг жилийн хугацаатайгаар байгуулав.

1.3.Уг гэрээнд Сэлэнгэ аймгийн Засаг дарга **Ерөө** сумын Засаг даргаас төсвийн санхүүжилтээр захиалж, хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний үр дүнд тавих шаардлага, гэрээний биелэлтийг дүгнэх болзол, бусад нөхцлийг тусгав.

1.4.Сэлэнгэ аймгийн Засаг дарга, **Ерөө** сумын Засаг дарга нарын хооронд байгуулсан энэхүү гэрээтэй холбогдох харилцааг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Төсвийн тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай, Захиргааны ерөнхий хууль, Өрсөлдөөний тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Тариалангийн тухай, Орон нутгийн хамгаалалтын тухай, Зөрчлийн тухай, Авлигын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай, Төрийн болон албаны нууцын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Усны тухай, Ойн тухай, Газрын тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Зөвшөөрлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай, Татварын багц хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.5.Энэхүү гэрээ нь харилцан тохиролцож баталсан нийт 17 хавсралт, “Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах баталгаа”-ны хамт хүчин төгөлдөр байна.

Хоёр.Аймгийн Засаг даргын эрх, үүрэг

2.1.Сэлэнгэ аймгийн Засаг дарга нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

2.1.1.Гэрээний нөхцлийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, ажил төрлийн байнгын уялдаатай ажиллана.

2.1.2.Гэрээний хэрэгжилтийг хангахтай холбогдуулан сумын Засаг даргад мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, мэдээллээр хангана.

2.1.3.Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн сангаас сумдад олгох орлогын шилжүүлгийн хуваарийг баталж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс сар бүр сумын төрийн сангийн дансанд шилжүүлнэ.

Гурав.Сумын Засаг даргын эрх, үүрэг

3.1.Сумын Засаг дарга нь дараах эрх, үүрэгтэй Үүнд:

3.1.1.Энэхүү гэрээний нөхцлийн дагуу ажил, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

3.1.2.Өөрийн сумын засаг захиргааны өмчлөгчийн эрх ашгийг хамгаалж хэрэгжүүлнэ.

3.1.3.Улсын төсвийн хөрөнгөөр ажил үйлчилгээ нийлүүлэх талаар өөрийн сумын нутаг дэвсгэр дэх төсвийн байгууллагын төсвийн шууд захирагч нартай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

3.1.4.Улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэх ажил үйлчилгээ болон түүний зарим хэсгийг гуравдагч этгээдээр /тухайн салбарт л хамаарах төсвийн байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж гэх мэт/ гүйцэтгүүлэхээр харилцан гэрээлсэн бол тэдгээрийг тогтоосон хугацаанд нийлүүлэх асуудлыг хариуцна.

3.1.5.Сумын Засаг дарга нь өөрийн хариуцсан улсын төсвийн байгууллагын хөрөнгийг төлбөр болон үйл ажиллагааны зардлын хэмнэлт Төсвийн тухай хуулийн дагуу аймгийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр тухайн төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зарцуулах эрх мэдлийг тусгай журмын дагуу шилжүүлнэ.

3.1.6.Сумын Засаг дарга нь тогтоосон журам, маягтын дагуу ажил үйлчилгээ нийлүүлэлтийн улирал, жилийн тайланг үнэн зөв гаргаж, батлагдсан хугацаанд

захиалагч /аймгийн Засаг дарга/-д хүргүүлэх ба ажил үйлчилгээ нийлүүлэх үүрэг, түүний үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцна.

3.1.7.Аймгийн Засаг даргын амаар болон бичгээр өгсөн үүрэг чиглэлд заавал албан бичгээр тухай бүр хариуг ирүүлнэ.

3.1.8.Энэхүү гэрээнд заасан тогтоосон хугацаанд тайланг ирүүлж, үнэлж, дүгнүүлнэ.

Дөрөв.Гэрээг дүгнэх, үнэлэх

4.1.Сумын Засаг дарга гэрээний биелэлтийг улирал бүрийн дараа сарын 05-ны дотор хавсралтад заагдсан ажил, арга хэмжээ бүрээр гаргаж тайлагнах бөгөөд жилийн эцсийн гүйцэтгэлийг 2024 оны 12-р сарын 15-ны дотор хүлээгдэж буй гүйцэтгэлээр тайлагнаж, үнэлж, дүгнүүлнэ.

4.2.Аймгийн Засаг дарга нь ажил, арга хэмжээний хэрэгжилтийн улирлын тайланд дүгнэлт хийж, жилийн тайланд үнэлгээ хийнэ. Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний тоо хэмжээ, чанарыг дараах арга, хэлбэрээр үнэлнэ.

а/Сумын Засаг даргаас ирүүлсэн тайлан, мэдээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 374 дүгээр тогтоолуудын дагуу үнэлж, дүгнэнэ.

б/Ажлын хэсэг томилж газар дээр нь үнэлгээ, дүгнэлт хийнэ.

Тав. Маргааныг шийдвэрлэх

5.1.Гэрээг байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлэхдээ доорх зарчмыг баримтална. Үүнд:

5.1.1.Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тоо хэмжээ, хугацаа, чанартай холбогдон үүссэн асуудлыг аль болох харилцан зөвшилцлийн дагуу шийдвэрлэж байх.

5.1.2.Ажил, арга хэмжээний өртгийг тодорхойлох, ажил, үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхтэй холбогдон үүссэн асуудлыг аймгийн Засаг даргын Тамгын газарт хандаж зохицуулах арга хэмжээ авч байх.

5.1.3.Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль, эрх зүйн холбогдолтой асуудлаар шаардлагатай гэж үзвэл аймгийн Засаг даргын Тамгын газарт хандаж зөвлөгөө авч ажиллах.

Зургаа.Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, хүлээх хариуцлага

6.1.Гадаад, дотоод орчин өөрчлөгдсөнөөс гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд хоёр тал бичгээр санал тавьж, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

6.2.Сумын Засаг даргын Монгол Улсын хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зөрчсөн үйлдэл гаргасан болон авлига, ашиг сонирхолын зөрчилд холбогдсон нь тогтоогдвол аймгийн Засаг даргын зүгээс гэрээг цуцлах эсвэл хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

6.3.Сумын Засаг дарга нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсхүл хангалтгүй биелүүлсэн, 2 улирал дараалан тайлагналтыг хугацаа хоцроож ирүүлсэн болон огт тайлагнаагүй, аймгийн хэмжээнд зохион байгуулж буй шуурхай болон нэгдсэн арга хэмжээ, хурал, сургалт, семинар, цугларалт, салбар чиглэлээр тайлан тавих ажилд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 удаа ирээгүй, хугацаатай, хариутай бичиг, тайлан, мэдээ, судалгааг ирүүлээгүй, удаа дараа хоцроосон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

6.4.Гэрээний өөрчлөлтийг тухай бүрд нь бичгээр үйлдэн аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга нар гарын үсэг зурж, гэрээний анхны эх хувьд хавсаргана. Гэрээний анхны болон нэмэлт, өөрчлөлт оруулсан эхүүдийн хувь тус бүрийг аймгийн Засаг дарга болон сумын Засаг дарга тус тус хадгална.

6.5.Гэрээнд тусгагдаагүй ажил, арга хэмжээ хэрэгжүүлэх асуудлыг талууд харилцан зөвшилцөж нэмэлт гэрээ байгуулах замаар шийдвэрлэж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

НАЦАГДОРЖИЙН ЛХАГВАДОРЖ

ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГА

БАТМӨНХИЙН СЭРГЭЛЭН

2024 оны 03-р сарын 04-ний өдөр

**АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН БОЛОН САНХҮҮ, ЁС ЗҮЙН
ЗӨРЧИЛ ГАРГАХГҮЙ АЖИЛЛАХ БАТАЛГАА**

2024 оны 03-р сарын 04-ны өдөр

Сэлэнгэ аймгийн **Ерөө** сумын Засаг дарга **Батмөнхийн Сэргэлэн** миний бие нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж 2024 онд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Захиргааны ерөнхий хуулийн 105 дугаар зүйлийн 105.1, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.6, 20 дугаар зүйлийн 20.3, 40 дүгээр зүйл, 70 дугаар зүйлийн 70.1, Авлигын эсрэг хуулийн 2, 3 дугаар бүлэг, 33 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 2, 3 дугаар бүлэг, 23, 27, 29 дүгээр зүйл, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйл, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7, 28 дугаар зүйл, Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4, Төрийн болон албаны нууцын тухай хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэн ажиллаж, дээрх хуулиудтай холбоотой төрийн болон албаны, хувь хүний нууцыг чанд хадгалж, хамгаалан, мэдээллийг задруулахгүй байх, Авлига, ашиг сонирхлын болон санхүүгийн, ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллахаа энэхүү баталгааны хуудсаар гаргаж байна.

Миний бие нь албаны чиг үүргийн дагуу олж мэдсэн мэдээлэл, холбогдох баримт бичиг болон хувь хүний нууцыг бусдад задруулах, үзүүлэх, дамжуулах, үрэгдүүлэх, хууль бусаар ашиглах зэрэг бусад байдлаар зөрчсөн тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Баталгаа гаргасан:
Ерөө сумын
Засаг дарга Б.Сэргэлэн



Баталгааг хүлээн авсан:
Сэлэнгэ аймгийн
Засаг дарга Н.Лхагвадорж



Ерөө сумын Засаг даргын
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №1



**ТӨРИЙН ЗАХИРГАА, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ**

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
1.1 Төр засгийн бодлого, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх хүрээнд:	
1.1.1.Монгол Улсын хууль, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж тайлагнах /Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, УИХ, Засгийн газрын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар/	Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдаж, үр дүн тооцогдсон байна.
1.1.2.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний суманд хамааралтай заалтын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцон иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдаж, үр дүн тооцогдон, иргэд олон нийтэд мэдээлэл хүрсэн байна.
1.1.3.Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, дээд шатны байгууллагаас өгсөн цаг үеийн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, тайлан мэдээ, хариутай бичгийг хугацаанд нь тайлагнаж ажиллах	Дээд шатны байгууллагуудын үүрэг даалгавар биелэгдэж, хугацаандаа тайлагнасан байна.
1.1.4.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, багийн иргэдийн Нийтийн Хурлын ажиллах нөхцөлийг хангаж ажиллах	Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдэнэ.
1.1.5.Аймгийн "Аялал жуулчлал, ногоон хөгжлийг дэмжих жил"-ийн төлөвлөгөөнөөс суманд хамааралтай зорилт, арга хэмжээг хяналтад авч хэрэгжүүлэн, үр дүнг тооцож тайлагнах	Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдаж, үр дүн тооцогдсон байна.
1.2. Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангаж, сахилга хариуцлагыг дээшлүүлэх хүрээнд:	
1.2.1."Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хуулийг сум, орон нутгийн хэмжээнд бүрэн хэрэгжүүлж, иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэх зарчмыг бүх шатны төрийн байгууллагуудад хэвшүүлэх, хяналт тавих	Иргэдийн сэтгэл ханамж дээшилнэ.
1.2.2.Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг 12 хоногт багтаан шийдвэрлэж, тайланг тогтоосон хугацаанд тухай бүр хүргүүлж, "Таныг сонсьё" арга хэмжээг төр, төсвийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Арга хэмжээ зохион байгуулагдаж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтот түвшинд хүргэсэн байна.
1.2.3.Монгол Улсын төрийн дээд одон медаль, салбарын болон аймаг, орон нутгийн шагналд иргэд, төрийн албан хаагчдыг холбогдох журмын дагуу тодорхойлох /Ардын Их Хурлын 1990 оны 148, МУ-ын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоол,	Дүрэм, журмын хэрэгжилт хангагдана.

аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 134 дүгээр тогтоол/	
1.2.4.Монгол Улсын төрийн дээд одон медаль, салбарын болон аймаг, орон нутгийн шагналаар шагнагдсан иргэдийн нэгдсэн судалгааг гаргаж, судалгаанд үндэслэн, иргэдийг шагналд тодорхойлоход анхаарах	Иргэдийн сэтгэл ханамж дээшилж, холбогдох дүрэм, журмын хэрэгжилт хангагдана.
1.2.5.Цахим хурлын төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, дээд шатны байгууллага, албан тушаалтнаас зохион байгуулсан цахим хурал, сургалт, зөвлөгөөнд тогтмол оролцох	Цаг хугацаа, зардал хэмнэгдэж, мэдээ, мэдээллийг түргэн шуурхай солилцох нөхцөл бүрдэнэ.
1.2.6.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон дагалдан гарсан дүрэм, журмыг хэрэгжүүлж, сум, тосгодын албан ёсны цахим хуудасны байнгын тасралтгүй ажиллагааг ханган, мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэх. Шаардлагатай тохиолдолд цахим хуудсыг шинээр хийлгэхэд холбогдох хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	Хуулийн хэрэгжилт хангагдаж, орон нутгийн мэдээ мэдээллийг авах нөхцөл боломж бүрдсэн байна.
1.2.7.Цахим шилжилтийн хүрээнд И-Монгол системээр сум, орон нутгийн иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг цахимаар операторын горимоор хүргэх үйл ажиллагаанд хяналт тавьж, дэмжлэг үзүүлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах	Төрийн үйлчилгээг шуурхай хүргэсэн байна.
1.2.8.Сум, орон нутгийн 16-аас дээш насны иргэдэд тоон гарын үсгийг олгох, хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Иргэдийн төрийн цахим үйлчилгээ болон бусад үйлчилгээ авах боломж нэмэгдэнэ.
1.2.9.Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /ERP/-д төр, төсвийн байгууллагуудыг нэвтрүүлэх, хяналт тавих	Сум, тосгодын төр, төсвийн байгууллагууд системд нэвтэрч, албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн байна.
1.3.Хүний нөөцийн хөгжлийг хангах ажлын хүрээнд:	
1.3.1.Монгол Улсын Засгийн газраас баталсан орон тооны хязгаарт багтаан сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог шинэчлэн батлахад дэмжлэг үзүүлэх	Тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдана.
1.3.2.Төрийн албаны зөвлөлөөс баталж, зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтын дагуу төрийн захиргааны албан хаагчдыг томилох, зөрчилтэй томилгоо хийхгүй байхад хяналт тавих	Тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.
1.3.3.Аймгийн хэмжээнд хийгдэх хүний нөөцийн суурь судалгаанд сум, тосгоны төр төсвийн бүх шатны байгууллагын төрийн албан хаагчдыг хамруулж, үнэн бодит мэдээллийг ирүүлэх	Судалгаанд үндэслэн төрийн албан хаагчдад чиглэсэн хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
1.3.4.Төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, тайланг хагас, бүтэн жилээр ирүүлэх	Сумын нийт төрийн албан хаагчдын 70-аас доошгүй хувийг хамруулсан байна.
1.3.5.Төрийн албан хэрэг хөтлөлтийг кирилл болон үндэсний бичгээр хослуулан явуулах ажлыг эхлүүлж, төрийн бүх шатны байгууллагуудад сургалт зохион байгуулах	Албан хаагчдын төрийн албан хэрэг хөтлөлт, үндэсний бичгийн мэдлэг чадвар дээшилнэ.
1.3.6.Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх, төрийн үйлчилгээний удирдах албан	Төрийн албаны тасралтгүй байдал хангагдана.

тушаалын сул орон тоо гарсан тухай бүрд захиалгыг Төрийн албаны тухай хууль, холбогдох журмын дагуу Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж нөхөх арга хэмжээг авах	
1.4.Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд:	
1.4.1.“Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай” Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01/01 дүгээр зөвлөмж, Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 75 дугаар зүйлийг чанд мөрдөж ажиллах	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдана.
1.4.2.Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ыг чанд мөрдөж ажиллах, ингэхдээ өөрийн эрх хэмжээний асуудлаар гадаад улсын адил түвшний байгууллага, эсхүл олон улсын байгууллагатай гэрээ байгуулах тохиолдолд уг журмын 4.1-т заасны дагуу гэрээг байгуулахаасаа 10 хоногийн өмнө гэрээний төслийг хянуулж, гэрээ байгуулах зөвшөөрөл авахаар шаардлага, бүрдэл хангасан гэрээний төслийг холбогдох материалын хамт ирүүлэх	Холбогдох зөвлөмжийг хэрэгжүүлж гадаад хамтын ажиллагааны нэгдмэл байдал сайжирна.
1.4.3.Гадаадад айлчлах, албан хэргээр зорчих, олон улсын арга хэмжээнд оролцох, албан ёсны яриа хэлэлцээ явуулахдаа арга хэмжээний удирдамжийн төсөл (удирдамжид айлчлалын ач холбогдлыг тусгасан байх) боловсруулж, арга хэмжээ болохоос ажлын 14-өөс доошгүй өдрийн өмнө ирүүлж санал авч байх, тагнуулын байгууллагад мэдэгдэх	Холбогдох журам хэрэгжиж, зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна.
1.4.4.Хувийн хэргээр гадаад улсад зорчихдоо албан ёсны уулзалт, яриа хэлэлцээ хийх, гэрээ байгуулах, ёслолын арга хэмжээнд оролцохгүй байх;	Зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна.
1.4.5.Гадаад улсад албан ёсны, эсхүл ажлын айлчлал хийсэн, албан хэргээр зорчсон, олон улсын арга хэмжээнд оролцсон, албан ёсны яриа хэлэлцээ явуулсан тухай илтгэх хуудасны хувийг ажлын 7 хоногийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх, тагнуулын байгууллагад хүргүүлэх	Гадаад арга хэмжээний зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна.
1.5.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцох ажлын хүрээнд:	
1.5.1.Бодлогын баримт бичгүүдийн суманд хамааралтай заалтын хэрэгжилтийг хангаж, үр дүнг иргэд олон нийтэд мэдээлж, тайлан мэдээг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлэх	Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт хангагдан иргэд олон нийтэд мэдээлж, хугацаанд нь тайлагнасан байна.
1.5.2. Аймгийн Засаг даргын 2017 оны А/458 дугаар захирамжийн дагуу Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг үнэлэх нийт 18 төрлийн тайланг тогтоосон хугацаанд анхан шатны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээг нэгтгэн баталгаажуулан тайлагнах	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг үнэн зөв, тогтоосон хугацаанд тайлагнаж хэвсэн байна.

1.5.3.Сум орон нутагт зохион байгуулсан ажил арга хэмжээний мэдээ, мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэлийн багт шуурхай дамжуулах, мэдээллийг солилцох, олон нийтэд мэдээлж хамтран ажиллах үр дүнтэй хэрэгжүүлэх	Орон нутгийн мэдээлэл олон нийтэд сурталчлагдсан байна.
1.6.Бусад ажил арга хэмжээ:	
1.6.1.Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Гамшиг ослын гаралт буурсан байна.
1.6.2.Үйлдвэрлэл, үйлчилгээний стандартын шаардлага ханган ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах	Төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагаа сайжирсан байна.
1.6.3.Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасны дагуу эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийх, зөвлөн туслах үйлчилгээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх	Төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмж, сайжирна.

___оОо___

Ерөө сумын Засаг даргын
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №2

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ 9055053

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
2.1. Авлигатай тэмцэх үндэсний /УИХ-ын 2023 оны 59-р тогтоол/ хөтөлбөрийг хэрэгжүүлж, авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ, аянуудыг зохион байгуулах.	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлууд зохион байгуулагдаж, сахилга хариуцлага дээшлэн, энэ төрлийн гэмт хэргийн тоо буурсан байна.
2.2. Хүний эрхийг хангах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах.	Хүний эрхийн зөрчил, гомдол буурсан байна.
2.3. Шинээр батлагдсан болон нийтлэг хамааралтай хууль тогтоомжуудыг үр дүнтэй оновчтой хэрэгжүүлэх, сумын төрийн албан хаагчид болон иргэдэд чиглэсэн сургалтыг тогтмол зохион байнуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, холбогдох сургалтад төрийн албан хаагчдыг хамруулах ажлыг зохион байгуулах.	Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны чанар, хүртээмж сайжирч, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг, боловсрол дээшилсэн байна.
2.4. Захиргааны шийдвэрийн хувийн хэргийг бүрдүүлж, зайлшгүй гаргах шаардлагатай захиргааны хэм хэмжээний актуудыг гарган мөрдүүлж, захиргааны шийдвэр гаргахдаа нөхцөл байдлыг тогтоон, сонсох ажиллагааг явуулж, иргэд, оролцогчдын оролцоог хангаж ажиллах.	Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоо нэмэгдэж, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт хангагдсан байна.
2.5. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам /МУЗГ-ын 2020 оны 246-р тогтоол/, Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам /МУЗГ-ын 2021 оны 226-р тогтоол/-ыг хэрэгжүүлж, архивын өрөө, зориулалтын техник хэрэгслийг шийдвэрлэн, БНШК-ын үйл ажиллагааг тогтмолжуулж, төр, төсвийн байгууллагуудын архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж ажиллах.	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт хангагдаж, архивын ажил үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан байна.
2.6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлыг үр дүнтэй төлөвлөн хэрэгжүүлж, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг өмнөх оноос бууруулах.	Хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилт хангагдан, гэмт хэргийн гаралт буурч, иргэдийн эрүүл, аюулгүй, тайван орчинд амьдрах нөхцөл бүрдсэн байна.
2.7. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгслийг сайжруулж, нэмэгдүүлэх болон 20-иос доошгүй хувийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бусад ажил арга хэмжээнд зориулан дараа оны төсөвт тусгах	Дүрс бичлэгийн техник, хэрэгслийг сайжруулж, нэмэгдүүлэн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулсан байна.
2.8. Суманд үйл ажиллагаа явуулж буй сүм хийдийг хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахад хяналт тавьж,	Төр, сүм хийдийн харилцаа хуулийн хүрээнд явагдаж, сүм

зөвшөөрөлгүй сүм хийдийг хуулийн этгээдийн бүртгэлд хамруулах, хамрагдаагүй сүм хийдийн үйл ажиллагааг таслан зогсоох.	хийдийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналт сайжирна.
2.9.Төр, нийтийн ашиг сонирхол хөндөгдөж төрд хохирол учирсан тохиолдолд холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан, Прокурорын газартай хамтран төрд учирсан хохирлыг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлж, арилгуулсан байна.
2.10.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Өрсөлдөөний тухай, Зар сурталчилгааны тухай хууль, ШӨХТГ-аас зарласан жилийн хүрээнд тодорхой ажлуудыг төлөвлөн зохион байгуулж, үр дүнг тооцох.	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдаж, хэрэглэгчийн эрх ашиг хамгаалагдсан байна.
2.11.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлж, бүртгэл судалгааг хуулийн дагуу явуулан тайлан мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газарт сар бүр мэдээлж тайлагнах.	Гадаадын иргэдийн оршин суух, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй байдалд төрөөс тавих хяналт сайжирна.
2.12.Улсын хил хамгаалалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, зарласан аян, ажил, арга хэмжээг Хил хамгаалах ангиудтай хамтран үр дүнтэй зохион байгуулж, Хилийн тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах.	Улсын хил хамгаалалтад оролцох иргэдийн оролцоо, нэмэгдэж, хил орчмын гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурсан байна.
2.13.Монгол Улсын ИХ Хурлын сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т зааснаар тойрогт нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбарыг хуульд заасан шаардлагын дагуу бэлтгэж, байршуулах ажлыг зохион байгуулах.	Хуулийг хэрэгжилт хангагдсан байна.

Ерөө сумын Засаг даргын
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №3

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

МЮА0005 9055053

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
3.1. "Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг зохион байгуулах	Байгалийн нөөцүүд, түүх соёлын дурсгалт зүйлийг зохистой ашиглах, хамгаалах сурталчилна.
3.2. Хонин нугын байгалийн үзэсгэлэнт газарт аялал жуулчлалын цогцолбор, жуулчны бааз байгуулах боломжийг судлах, эрх зүйн орчинг бий болгож, хувийн хэвшилд дэмжлэг үзүүлэх	Байгалийн үзэсгэлэнт газарт шинэ бүтээн байгуулалт нээгдсэн байна.
3.3. "Аялал жуулчлал ногоон хөгжлийг дэмжих жил"-ийн хүрээнд аялал жуулчлалын салбарын аж ахуйн нэгж, иргэдийн үйлчилгээний газрын гадна дотно тохижилт, өнгө үзэмж, үйлчилгээний чанарыг сайжруулж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	Үйлчилгээний чанар сайжирч, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн газрууд, ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдэнэ.
3.4. "Минжийн рашаан", "Ерөөгийн халуун рашаан", "Баян голын рашаан" зэрэг эмчилгээний ач холбогдолтой "Халуун рашаан"-г хувийн хэвшил болон иргэдэд гэрээгээр эзэмшүүлэн шинээр ресорт байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх	Эрүүл мэндийн аялал жуулчлалын урсгал нэмэгдэнэ.
3.5. НИТАЖ-ын хүрээнд малчин, мал бүхий иргэдийг жуулчин хүлээн авдаг, номадик соёлыг сурталчлах, ахуйн орлого ашгаа нэмэгдүүлэх боломжийг таниулах, дэмжих	Аялал жуулчлалын салбар тогтвортой хөгжиж, аялагчдын тоо нэмэгдэж, аялал жуулчлал эрхлэгчдийн ашиг орлого нэмэгдэнэ.
3.6. Гол мөрний сүлжээг түшиглэн усан аялалыг хөгжүүлэх эхлэлийг тавих иж бүрэн судалгааг хийх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож хөгжүүлэх (Завь, мөсөн сур, цас мөсний баяр, нохой чарга, морин чарга, загасчлах аяллын төрлүүдээр баяжуулах)	Усан аялал, экстрим аяллын төрөл нэмэгдэж, жуулчдын тоо өснө.
3.7. Зам дагуух хаяг тэмдэгжүүлэлтүүдийг шинэчилж, QR кодтой самбар байрлуулах	Жуулчдад зориулсан мэдээллийн чанар, хүртээмжийг сайжирч, үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй хөнгөн шуурхай хүргэх нөхцөл бүрдэнэ.
3.8. Түүх дурсгалын болон байгалийн үзэсгэлэнт газар, цэцэрлэгт хүрээлэн, цогцолбор газар, жуулчны бааз, амралтын газруудын цэвэр бохир ус, био 00, агааржуулалтын системийг стандарт шаардлагад нийцүүлэн хог хаягдалгүй эко орчинг бүрдүүлж, дэд бүтцийг сайжруулах	Эко аялал жуулчлал хөгжиж, жуулчдын ая тухтай, аюулгүй зорчих нөхцөл бүрдэж, аялагчдын тоо нэмэгдэж, аялал жуулчлал эрхлэгчдийн ашиг орлого нэмэгдсэн байна.
3.9. "YERUU CUP" мөсөн сурын харваа наадмыг олон улсын түвшинд хүргэж, жуулчдад борлуулах, маркетингийг идэвхижүүлэх	Орон нутгийн аялал жуулчлалын өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

3.10."Ерөөгийн халуун рашаан" явах замд Хотонгийн даваанд "Гацуур", "Хуш", "Жодоо", "Нарс", "Шинэс" зэрэг 5 төрлийн шилмүүст модыг ажиглах морин аяллын маршрут боловсруулах	Нутгийн иргэдэд түшиглэсэн аж жуулчлалыг хөгжүүлнэ.
3.11.Жуулчдын сэтгэлийг татах маркетинг сурталчилгааг идэвхжүүлэх, сумаа сурталчилсан кино, шторкуудыг бэлтгэх	Аялал жуулчлалын маркетинг сурталчилгаа идэвхжсэн байна.
3.12.Ерөө голын Тулын тохойнд загасчлах аялал, Тул загас ажиглах аялал хөгжүүлэх	Аялал жуулчлалын ховор төрлөөр өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

___оОо___

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
4.1.Улс, аймаг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон гадаад, дотоодын зээл, тусламжаар хэрэгжиж буй хөдөө аж ахуйн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллах	Улс, аймаг, орон нутгийн төсвөөр болон гадаад, дотоодын зээл, тусламж, санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд тогтмол хяналт тавьж, тайлан, мэдээг ирүүлсэн байна.
4.2.“Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын албан даалгаврын хэрэгжилтийг хангаж үр дүнг сар бүр тайлагнаж ажиллах	Сум бүр өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд бүрдүүлбэл зохих өвс тэжээлийг 100 хувь бүрдүүлж, өвөл, хаврыг өнтэй даван туулах бэлтгэл ажлыг бүрэн хангана.
4.3.Тариалангийн бүс нутагт үржүүлж буй мал сүрэгт үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, стандартын шаардлага хангасан үржлийн малыг ялган тэмдэглэж, эрчимжсэн аж ахуйг нэмэгдүүлэх	Сумын хэмжээнд баталгаажсан үүлдрийн 500 үхэр, 1500 хонь нийт 2000 толгой малд үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлж, цөм сүрэг бүхий айл өрхөөс үржлийн хээлтэгч хээлтүүлэгч бойжуулж орон нутгийг үржлийн хээлтүүлэгчээр хангах боломжийг бүрдүүлсэн байна.
4.4.Сумын нийт мал сүргийн 20-иос доошгүй хувийг эдийн засгийн эргэлтэнд оруулах.	Сумын хэмжээний адуун сүргийн 30 хувь буюу 2608 адуу, үхэр сүргийн 20 хувь буюу 4079 үхэр, хонин сүргийн 30 хувь буюу 9555 хонь, ямаан сүргийн 30 хувь буюу 7783 ямаа нийт 21417 толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан байна.
4.5.Өвөлжилт хүндэрсэн, хүндэрч болзошгүй сумдад малын өвс, тэжээл, эм, эмчилгээний хэрэгсэл, өргөн хэрэглээний болон хүнсний бараа, бүтээгдэхүүнийг хүргэх, цаг агаарын мэдээ, мэдээллийг шуурхай дамжуулах ажлыг тогтмол зохион байгуулах	Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлсэн байна.
4.6.Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 1-ээс доошгүй худгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулсан байна.
4.7.Нийт мал сүргийн дунд эзлэх өндөр ашиг шимт мал сүргийн тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	Нийт сүрэгт эзлэх цэвэр эрлийз үхрийн тоог 10 хувиар нэмэгдүүлсэн байна.
4.8.2023 оны тариалалтын төлөвлөгөөний дагуу таримал тус бүрийн тариалалтыг 5 хувиар нэмэгдүүлж зорилтот ургацыг хураан авах, өмнөх оны нийт тариалсан талбайн 10 хувиас ихгүй талбайд тосны ургамал тариалах	2023 онд өмнөх онд тариалсан талбайн хэмжээг 5 хувиар нэмэгдэж, тосны ургамлын тариалалтын талбайн хэмжээ нийт эргэлтийн талбайнаас 10 хувиар хэтрүүлэхгүй тариалсан байна.

4.9. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлж, агро-ойн аж ахуй байгуулах	Жимс, жимсгэний ургацын хэмжээг өмнөх оноос 10 хувиар нэмэгдүүлж, агро-ойн аж ахуй байгуулсан байна.
4.10. Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, газар олгох, хөрөнгө оруулалтыг татах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Сум бүр 100 м2-аас доошгүй өвлийн хүлэмж байгуулсан байна.
4.11. Усалгаатай тариалангийн хэмжээг нэмэгдүүлэх	Усалгаатай тариалангийн хэмжээг өмнөх оноос 10 хувиар нэмэгдүүлэн сумын хэмжээнд ашиглагдаж байгаа услалтын системүүдыг паспортжуулсан байна.
4.12. Эрүүл ахуй, чанар, стандартын шаардлага хангасан зоорь, агуулах, элеваторын тоо хэмжээг нэмэгдүүлэх, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах	Эрүүл ахуй, чанар, стандартын шаардлага хангасан зоорь, агуулах, элеваторын тоо хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэн бүртгэлжүүлсэн байна.
4.13. Газар тариалангийн бүртгэлийн /plant.mofa.mn/ цахим мэдээллийн санд тариалан эрхлэгчид, ногоочдыг бүртгэлжүүлж, зөвлөн туслах	Урамшууллын төрөл хэмжээ, урамшуулалд хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо гаргаж, үр дүнг тооцсон байна
4.14. "Адра" Олон Улсын байгууллагатай хамтран "Органик хөдөө аж ахуйн түншлэл" II төслийг хэрэгжүүлэн хамтын баталгаажуулалтын байгууллагыг байгуулах ажлыг эрчимжүүлэх, шинээр байгуулах	"Адра" Олон Улсын байгууллагатай хамтран "Органик хөдөө аж ахуйн түншлэл" II төслийг хэрэгжүүлж, хамтын баталгаажуулалтын байгууллага 1-ээс доошгүй байгуулсан байна.
4.15. Дахин боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр иргэд, аж ахуйн нэгжүүдэд Мэргэжлийн холбоог түшиглэн сургалт зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх	Сум бүр 1-ээс доошгүй түүхий эд авах цэгийг байгуулсан байна.
4.16. Малын тоо толгойн албан татварын орлогын 30-аас дээш хувийг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах	Малын тоо толгойн албан татварыг бүрэн төвлөрүүлж, татвараас төвлөрсөн санхүүжилтийн 30-аас дээш хувийг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан байна.
4.17. Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээг технологит хугацаанд шуурхай зохион байгуулж, өвчингүй тайван байдлыг хангах (Халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шимэгчтэх өвчнөөс урьдчилан болон эмчлэн сэргийлэх, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн арга хэмжээ, лабораторийн оношлогоо шинжилгээ хийх)	Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчингүй тайван байдлыг хадгалж, нийтийн эрүүл мэндийг хамгаалж, хүнсний аюулгүй байдлыг хангасан байна.
4.18. Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй хувийн мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүдийн материаллаг баазыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүдийн материаллаг баазыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.
4.19. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж мал, амьтны шилжилт хөдөлгөөн, отор нүүдлийг мал эмнэлгийн үзлэгт хамрагдсан гарал үүслийн гэрчилгээг үндэслэх, зохион байгуулах, хяналт тавих	Мал, амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг чангатгаж, отор нүүдлээр ирсэн малчдад төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэсэн байна.

Ерөө сумын Засаг даргын
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №5

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУЛ УУРАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН
АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ**

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
5.1.Ойн санг гэрээгээр эзэмшиж буй нөхөрлөлүүдтэй хамтран ажиллах гэрээг шинэчлэх, үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах	Гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдийн үйл ажиллагаа сайжирсан байна.
5.2.Сумын хэмжээнд "Тэрбум мод" аяныг өрнүүлэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулах, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	Ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдсэн байна.
5.3.Хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор хогийн цэгийн тархалтыг багасгаж, хашаажуулан, эх үүсвэр дээр нь ангилан ялгах, тээвэрлэлтийг тогтмолжуулах	Иргэдийн ая тухтай, цэвэр цэмцгэр, эрүүл орчинд амьдрах нөхцөл бүрдсэн байна.
5.4."Стандартын шаардлагад нийцээгүй нүхэн жорлонг үе шаттайгаар устгах, булшлах замаар "Эко болон боловсон жорлон"-г нэмэгдүүлэх	"Стандартын жорлон"-г хэрэглэж, хөрс бохирдохоос хамгаалагдсан байна.
5.5.Булаг, шандын эхийг тохижуулах ажлыг зохион байгуулах	Булаг шандын эх хамгаалагдаж, ундарга сайжирсан байна.
5.6.Цөлжилтийн судалгаанд тулгуурлан үр шим нь буурсан тариалангийн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах, бэлчээрийн талхагдлыг бууруулах, сэлгэх, чөлөөлөх, шимт ургамал тарималжуулах ажлыг хийж гүйцэтгэх	Цөлжилт багасаж, ойн зурвас байгуулсан тариалан талбай нэмэгдэнэ. Бэлчээрийн талхагдал буурна. Ойжуулалтын талбай хэмжээ нэмэгдсэн байна.
5.7.Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд магадлан итгэмжлэл хийлгүүлэн, ойн нөөцийг үр ашигтай ашиглах	Магадлан итгэмжлэгдсэн ойн мэргэжлийн байгууллагын тоо, Ойн нөөцийг үр ашигтай ашиглаж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний тоо нэмэгдсэн байна.
5.8.Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, эргүүл, пост ажиллуулах, сургалт, сурталчилгааг зохион байгуулах	Ой, хээрийн түймрийн тоо хэмжээ буурч, иргэд ой хээрийн түймрийн эрсдлээс урьдчилан сэргийлэх мэдлэг үр чадвартай болсон байна.
5.9.Ой, хээрийн түймэр гарсан тохиолдолд эзэн холбогдогчийг тогтоох, түймрийн улмаас экологид учирсан хохирлыг буруутай этгээдээс нэхэмжлэн барагдуулах ажлыг зохион байгуулах	Хариуцлагын тогтолцоо сайжирна.
5.10.Ой хээрийн түймэрт шатсан талбайг нэн тэргүүнд ойжуулах арга хэмжээ авах, ойжуулсан талбайд мал бэлчээхгүй байх	Ой хээрийн түймэрт шатсан талбай нөхөн сэргээгдсэн байна.
5.11.Газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын гэрээг дүгнэж, төлбөрийг төвлөрүүлэх	Газрын төлбөрийн орлого биелсэн байна.
5.12.Газар өмчлөхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлан газар өмчлүүлэх	Газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөл боломж бүрдсэн

ажлыг эрчимжүүлэх	байна.
5.13.Хүрээлэн буй орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах.	Гэмт хэргийн тоо буурна
5.14.Түгээмэл тархацтай, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гаргаж, тусгай зөвшөөрөлтэй болон хууль бусаар ашигласан талбайн нөхөн сэргээлтийг холбогдох байгууллагаар хяналт тавиулан гүйцэтгүүлэх	Хуулийн хэрэгжилт хангагдаж, нөхөн сэргээлт хийгдсэн байна.
5.15.Уул уурхайн үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналтыг сайжруулж, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлыг гүйцэтгүүлэх	Иргэдийн хяналт сайжирсан байна. Нөхөн сэргээлт хийсэн талбай нэмэгдсэн байна.
5.16.Уул уурхайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээр хийлгэн, аймаг, сумын хамтарсан комисст хүлээлгэн өгөх	Ашиглалтанд өртсөн талбайд нөхөн сэргээлт хийгдсэн байна.
5.17.Бичил уурхай эрхлэгчдийн судалгааг хагас, бүтэн жилээр байдлаар шинэчлэн гаргах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн, нөхөн сэргээлт хийлгэхэд хяналт тавих	Судалгаа шинэчлэгдэн, бичил уурхайчдын үүрэг хариуцлага нэмэгдсэн байна.
5.18.“НӨХӨН СЭРГЭЭЛТ-2024” нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд сумын хэмжээнд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах	Төлөвлөгөө хэрэгжсэн байна. Нөхөн сэргээгдсэн талбайн хэмжээ өссөн байна.
5.19.Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ашигт малтмалын боловсуулалтын түвшинг нэмэгдүүлэх	Хариуцлагатай уул уурхай эрхлэгчид нэмэгдэж, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэл хөгжиж байна.
5.20. Геологи уул уурхай, Экологийн албатай хамтарсан хяналт шалгалтын тоог нэмэгдүүлж, илэрсэн зөрчлийг тооцох, хуулийн хэрэгжилтийг хангуулах	Хуулийн хэрэгжилт хангагдаж, илэрсэн зөрчилд хариуцлага тооцогдсон байна.
5.21.Сумын хэмжээнд 2024 онд ахуйн зориулалтаар агнах барих амьтны тоо хэмжээний батлагдсан хуваарийн дагуу олгох.	Ахуйн зориулалтаар агнах амьтны орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх үйл ажиллагаанд зарцуулсан байна.
5.22.Сумын агнуурын бүс нутгуудыг эзэмшүүлэх менежмент хариуцагчтай болж дэмжлэг үзүүлэн ажиллах.	Агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагчтай болж нарийвчилсан менежмент төлөвлөгөө хийлгэсэн байна.
5.23.Ойн нөөцийн орлого төвлөрүүлэн, өөрийн хөрөнгөөр 421 га талбайд ойжуулалтын ажлыг гүйцэтгүүлсэн байна.	Үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар хэрэглээний мод -28878 м ³ , түлээний мод -13205 м ³ бэлтгэн, өөрийн хөрөнгөөр 421 га талбайд ойжуулалтын ажлыг гүйцэтгүүлсэн байна. Ойн нөөц ашиглалтын орлого 518,1 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Ерөө сумын Засаг даргын
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №6

**ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ӨРХИЙН АЖ АХУЙГ
ДЭМЖИХ, АЖИЛ АРГА ХЭМЖЭЭ**

МНОА0005 9055053

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
<p>6.1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2023 оны "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тогтоох тухай" А/470/А-327/А-306 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, Төрийн үйлчилгээний нэгдсэн систем www.e-mongolia.mn-оор согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр болон сунгалтын үйлчилгээг авах</p>	<p>Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог аймаг, суманд 1000 хүн ам тутамд 4 хүртэл байна. Үйлчилгээг нэвтрүүлсэн байна.</p>
<p>6.2.Хууль тогтоомжийг таниулах, үйлчлүүлэгч согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйлчилгээний арга барилыг төлөвшүүлэх зорилготой "Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалт"-ыг зохион байгуулах</p>	<p>Сумын хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн бусдад үйлчлэх үүрэг бүхий ажилтанг бүрэн хамруулсан байна.</p>
<p>6.3.Орчин үеийн шаардлагад нийцсэн сүлжээ дэлгүүр, үйлчилгээний газрыг хувийн хэвшлийн түншлэлээр ашиглалтад оруулах</p>	<p>Орчин үеийн чанар стандартад нийцсэн худалдаа үйлчилгээний цогц төвийг ашиглалтад оруулсан байна.</p>
<p>6.4.Сумдын баялаг бүтээгчдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, үзэсгэлэн худалдаа, экспо арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>Үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, борлуулалт нэмэгдсэн байна.</p>
<p>6.5.Жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйн эрхлэгчдийн бүтээмжийг нэмэгдүүлж, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлж, чанар, стандартын шаардлага хангасан, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх</p>	<p>Үйлдвэрлэл, үйлчилгээнүүдийг бий болж, бүтээмжийг сайруулж, дотоодын үйлдвэрлэлийн хангамж нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн байна.</p>
<p>6.6.Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд шаардлагатай эргэлтийн хөрөнгө тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих</p>	<p>Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэж, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлдвэрлэл бий болсон байна.</p>
<p>6.7.Худалдаа үйлчилгээний салбарт ажиллагсдын дунд "Ажил мэргэжлийн уралдаан", "Гадаад, дотоодын туршлага судлах аялал", сургалтуудыг зохион байгуулах.</p>	<p>Уралдаан, туршлага судлах аялалыг зохион байгуулж, ур чадвар, үйлчилгээний соёл дээшлүүлсэн байна.</p>
<p>6.8.Төрийн худалдан авалтад дотоодын жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэн хөгжүүлж, хэрэглэгч, үйлдвэрлэгчийг холбон дэмжих</p>	<p>Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийн түвшинг өмнөх оноос ахиулсан байна.</p>
<p>6.9.Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг сайжруулж, чанаргүй зээлийн хэмжээг бууруулж, түүхий эд нөөцөд тулгуурласан боловсруулах үйлдвэрлэлийг бий болгох.</p>	<p>Зээлдэгчийн мэдээллийг ЗМС-д нэгтгэж, мэдээлэл солилцоог сайжруулж, чанаргүй зээлийн эзлэх хувийг өмнөх оныхоос 30 хувиар бууруулж, үйлдвэрлэлийг бий болсон байна.</p>
<p>6.10.Сумын хэмжээнд мал, мах худалдаалах</p>	<p>Эрүүл ахуйн шаардлага хангасан</p>

зориулалтын цэг байгуулах	стандарт нийцсэн зориулалтын цаг байгуулсан байна.
6.11."Аялал жуулчлал ногоон хөгжлийг дэмжих жил"-ийн хүрээнд худалдаа үйлчилгээний салбарын аж ахуйн нэгж, иргэдийн үйлчилгээний газрын гадна дотно тохижилт, өнгө үзэмж, үйлчилгээний чанарыг сайжруулж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	Үйлчилгээ чанар сайжирч, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн газрууд, ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдэнэ.
6.12.Арьс шир, ноос, ноолуурын анхан шатны боловсруулах, үйлдвэр цех байгуулах иргэд аж ахуй нэгжид дэмжлэг үзүүлэх	Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанар сайжирч, борлуулалт нэмэгдсэн байна.
6.13.Орон нутгийн бизнес эрхлэгчдийг чадавжуулах, туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулах	Бизнес эрхлэгчдийн мэдлэг чадвар дээшилнэ.
6.14."Сум бүрт нэг үйлдвэр үйлчилгээ хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцох	Үйлдвэр үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн байна.
6.15.Орон нутгийн хүн амыг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр хангах, нөөц бүрдүүлэх, нөөцийн гэрээ байгуулах	Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөц бүрдүүлсэн байна.
6.16.Төвөөс алслагдсан баг, тосгонд явуулын ахуйн үйлчилгээг хүргэх арга хэмжээг зохион байгуулах.	Ахуйн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.
6.17."Хөх сав, канистергүй сум" хөдөлгөөнийг эрчимжүүлэн сав баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг дэмжин хүнсний зориулалтын бус хуванцар савны хор хөнөөлийг сурталчлах	Нэг өрхийн зориулалтын бус хуванцар савны хэрэглээг 15 хувиар бууруулж, хүнсний сав, баглаа боодлын хэрэглээний талаар хэрэглэгчдэд зөвлөиж, зөвлөгөө, сэрэмжлүүлэг түгээн сурталчилна.
6.18.Орон нутгийн онцлог бүхий уламжлалт брэнд хоол, идээ ундааг шинээр бий болгох, хөгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх	Үйлчилгээний газрын хоолны цэсэд тусгаж, нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлнэ.
6.19.Сумдын брэнд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн бэлгийн багц гарган зах зээлд нийлүүлэх	Брэнд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн 2 доошгүй бэлгийн багцыг худалдаанд гарган борлуулна.

Ерөө сумын Засаг даргын
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №7

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
7.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Сэлэнгэ аймгийн 2021-2025 онд хөгжлүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдуулан төлөвлөх	Төлөвлөгөөнд тусгахаар ирүүлсэн саналууд бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан үе шаттай төлөвлөгдсөн байна.
7.2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээг "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын дагуу сумын иргэдийн 80-аас доошгүй хувийг саналд үндэслэн аймгийн богино, дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөх, төлөвлөлт болон гүйцэтгэлийг Орон нутгийн удирдлагын системд бүрэн байршуулах	Орон нутгийн хөгжлийн сангаар санхүүжигдэн хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлт сайжирч, иргэдийн оролцоо нэмэгдэнэ.
7.3.2025 оны Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний саналыг иргэдийн саналд үндэслэн, мэргэжлийн байгууллагаар баталгаажсан зураг, төсвийг үндэслэн Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалын дагуу боловсруулан 2024 оны 06 дугаар сарын 10-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх	Хөтөлбөр, төсөл, арга хэмжээг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад тусгуулах суурь нөхцөл хангагдсан байна.
7.4.2024-2025 оны Улс болон аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Ерөө сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засвар, 400 суудалтай Соёлын төвийн барилга, Ерөө сумын төвөөс Бугант чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 27.8 км, Бугант тосгоны захирагчийн албаны хуучин байрны их засвар, Бугант тосгоны ариутгах татуургын шугамын засвар шинэчлэлтийн ажил, Ерөө сумын гудамж талбайн тохижилтын ажил, Ерөө сумын ногоон байгууламжийн ажил, Цахим төрийн албан хаагчийн тоног төхөөрөмж, Цэцэрлэгийн тоног төхөөрөмж, Бугант тосгоны багш хөгжлийн төв байгуулах ажлуудын гүйцэтгэлд ашиглагчийн хяналт тавьж ажиллах	Худалдан авах ажиллагаа ил тод явагдаж, орон нутагт ажлын байр бий болсон байна.
7.5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн хөрөнгөөс авсан дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний тайлан, Улсын, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээнд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангасан, өрхийн үйлдвэрлэгчдээс бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан талаарх тайланг нэгтгэн ирүүлэх	Орон нутгийн өрхийн үйлдвэрлэгчид дэмжигдсэн байна.
7.6.Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэлжүүлж, өмчид бүртгэн, ашиглагч байгууллагыг тодорхойлон, хөрөнгө эзэнгүйдэх асуудлыг таслан зогсоох	Хөрөнгө оруулалтын үр өгөөж нэмэгдэж, ашиглалт сайжирсан байна.
7.7.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж, гүйцэтгэл удааширсан, зогсонги байдалд орсон төсөл арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр ажил арга хэмжээ зохион байгуулж ажиллах	Ажил эрчимжүүлэх чиглэлээр ажил арга хэмжээ зохион байгуулсан байна.

7.8.Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтад албан хаагчдыг хамруулж чадавхжуулахад анхаарч ажиллах	Холбогдох албан хаагчдыг 2-с доошгүй сургалтад хамруулж чадавхжуулсан байна.
7.9.Төсвийн хөрөнгө оруулалтаар дутуу хийгдэж буй төсөл арга хэмжээний ажлуудыг чанарын баталгаат хугацаа дуусгуулах, Шүүх хяналтын байгууллага дээр шалгагдаж буй удааширлалтай байгаа төсөл арга хэмжээний ажлуудыг эрчимжүүлж дуусгуулах.	Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл сайжирна.
7.10.“Нээлттэй Сэлэнгэ” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хагас, бүтэн жилээр тайланг ирүүлэх	“Нээлттэй Сэлэнгэ” хөтөлбөрийг хэрэгжүүлэн үр дүнд тогтмол хяналт тавьж, тайлан, мэдээг ирүүлсэн байна.

___оОо___

Ерөө сумын Засаг даргын
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №8



**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН
АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ**

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
8.1 Сумын хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, төлөвлөлтийн дагуу бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэх	Хот төлөвлөлт газар зохион байгуулалтын оновчтой төлөвлөлт бий болж орчин нөхцөл сайжирсан байна.
8.2.МУ-ын Засгийн газрын 483 дугаар тогтоолын дагуу "Төрийн албан хаагчын орон сууц" арга хэмжээг хэрэгжүүлэх	Төрийн албаны хүний нөөцийн хангамж нэмэгдэнэ.
8.3."Амины орон сууц" арга хэмжээг хэрэгжүүлэх	Иргэдийн амьдрах нөхцөл дээшилнэ.
8.4.Төв суурин газрын ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх ажлыг иргэд, аж ахуйн нэгжийн санаачлага оролцоотойгоор хийх	Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний чанар, хүртээмж дээшилнэ.
8.5.Спорт цогцолборын барилга, залуучуудын чөлөөт цаг өнгөрөөх талбай, цэцэрлэгт хүрээлэн байгуулах	Хүүхэд залуучуудын чөлөөт цаг болон бие бялдараа хөгжүүлэх тав тухтай орчин бүрдэнэ.
8.6."Хашаандаа сайхан амьдарцгаая", "Сумандаа сайхан амьдарья" аяныг өрнүүлж үр дүнг тооцох	Аймаг, сумын өнгө үзэмж, иргэдийн ая тухтай амьдрах орчин бүрдэнэ.
8.7. Гэр хорооллыг инженерийн шугам, дэд бүтцэд холбох. Шинэчлэх, солих, засварлах шаардлагатай инженерийн шугам сүлжээний ажлыг хийж хэрэгжүүлэх	Дулааны алдагдал буурч, өртөг зардал хэмнэгдэж, иргэд тав тухтай амьдрах нөхцөл бүрдэнэ.
8.8.Эрүүл мэндийн төвүүдийн засвар үйлчилгээ, өргөтгөлийн барилгын ажлыг хийж, хүчин чадлыг нэмэгдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Эрүүл мэндийн төвүүдийн иргэдэд үйлчлэх үйлчилгээ болон иргэд үйлчлүүлэх тав тухтай орчин бүрдэнэ.
8.9.Ерөө-Бугант чиглэлийн хатуу хучилттай 74 км автозамыг барьж байгуулах, холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлж автозам барих ажлыг эхлүүлэх	Авто замын ашиглалт уртсаж, иргэдийн ая тухтай авто замаар зорчих нөхцөл бүрдэнэ.
8.10."Сумын хөгжил:Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх	Иргэдийн амьдрах тав тухтай аюулгүй орчин бий болно.
8.11.Зам, барилга, байгууламж, Барилгын ногоон байгууламж, инженерийн шугам сүлжээг шинээр барьж байгуулах, өргөтгөл, шинэчлэлт хийх тохиолдолд инженер геологийн судалгаа, дүгнэлт, хангагч байгууллагаас олгосон техникийн нөхцөлийг үндэслэн хийлгэж, эрүүл ахуйн болон шугам сүлжээний хамгаалалтын зурвас газрыг тогтоосон захирамж шийдвэрийг гаргасан байх.	Мэргэжлийн байгууллагаас олгосон техникийн нөхцөлийг үндэслэн хийснээр илүү чанартай зам, барилга, байгууламж баригдаж иргэд чанартай, баталгаатай орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.
8.12.Гэнэтийн болон давагдашгүй хүчин	Иргэдийн тав тухтай аюулгүй амьдрах

<p>зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн нөхцөлд инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн хэвийн ажиллагааг хангах, засвар, арчлалтын ажлыг шуурхай гүйцэтгэх зорилгоор материал, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах, анхааруулах мэдээлэл, тэмдэглэгээг хийж бэлтгэсэн байх</p>	<p>нөхцөл бүрдэнэ.</p>
<p>8.13.Орон нутгийн болон хот хоорондын нийтийн зорчигч тээвэр, шуудан тээврийн үйлчилгээг журмын дагуу зохион байгуулж цагийн хуваарь, маршрутыг мөрдүүлэх.</p>	<p>Орон нутгийн болон хот хоорондын нийтийн зорчигч тээвэр, шуудан тээврийн үйлчилгээ түргэн шуурхай цаг хугацаандаа ажиллах боломж бүрдэнэ.</p>
<p>8.14.Шаардлага хангахгүй,ашиглагдахгүй болсон эрчим хүч, холбооны агаарын шугамуудыг буулгах,гудамж талбайг хаягжуулах, суурилуулсан хяналтын камерын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах</p>	<p>Иргэд илүү найдвартай баталгаатай орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.</p>
<p>8.15.Цахилгаан (холбоо) дамжуулах, түгээх сүлжээний агаарын болон кабель шугам, дэд станцын хамгаалалтын зурвасыг тогтоох, мэдээллийг орон нутгийнхаа Газрын кадастрын нэгдсэн мэдээллийн сан болон Хот байгуулалтын нэгдсэн кадастрын мэдээллийн санд бүртгэх, хамгаалалтын зурваст цаашид газар олгохгүй байх, олгосон газрыг чөлөөлүүлэхэд орон нутгийн холбогдох байгууллага, иргэдтэй харьцаж асуудал шийдвэрлэхэд туслах зэргээр хууль тогтоомжийн хүрээнд бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажиллах</p>	<p>Иргэд илүү найдвартай баталгаатай орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.</p>
<p>8.16.Барилга, объект, орон сууцнуудын инженерийн шугам сүлжээний ашиглалтыг сайжруулах, халаалтын системээс зүй бусаар ус авах асуудлыг зогсоох, дотор халаалтын шугам хоолой, халаах хэрэгслийг угаах, нягтын шахалт хийлгэх талаар хангагч байгууллагатай хамтран зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах</p>	<p>Иргэдийн тав тухтай аюулгүй амьдрах нөхцөл бүрдэнэ.</p>

Ерөө сумын Засаг даргын
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №9




БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
9.1. Хүүхдийг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээнд заавал хамруулахын зэрэгцээ малчдын болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийг тэгш хамруулах, хөгжлийг дэмжих	Хүүхэд бүрийн онцлогийг харгалзан боловсрол эзэмших тэгш боломжоор хангасан байна.
9.2. Хичээл, сургалтын хоцрогдлыг нөхөж, сургалтын чанарыг дээшлүүлэн, элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж түвшинг ахиулах	Өмнөх оноос ахиулсан байна.
9.3. "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлж, чадварлаг багш нарыг урамшуулах бодлого баримтлах	Багшийн гүйцэтгэлд ахиц гаргаж үр дүнг тооцсон байна.
9.4. Сургалтын байгууллагыг ухаалаг төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх	Цахим сургалтын орчин, нөхцөлийг бүрдүүлсэн байна.
9.5. Цэцэрлэг, сургууль, дотуур байрны орчинд хүүхэд бүрийг хөгжүүлэх, хамгаалах	Хүүхдийн хөгжих, хамгаалуулах, сурч, хөгжих ээлтэй орчныг бүрдүүлсэн байна.
9.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурах, хөгжих, хамгаалуулах эрхийг хангаж, сургалтын таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх	Тусгай хэрэгцээт хүүхэд бүрийн онцлогийг харгалзан дэмжлэг үзүүлж, орчинг бүрдүүлэн, боловсрол эзэмших тэгш боломжоор хангасан байна.
9.7. Орон нутгийн иргэдэд насан туршдаа суралцах тэгш боломжийг олгох, шаардлагатай нөхцлийг нь бүрдүүлэх	Боловсролын үйлчилгээний чанарт ахиц гарсан байна. Иргэдэд насан туршдаа суралцах тэгш боломж, нөхцөлийг бүрдүүлж, Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтууд, зөвлөн туслах ажил үйлчилгээг үзүүлсэн байна.
9.8. Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлийн нөхцөлийг сайжруулж, мэргэжлийн хүний нөөцөөр хангах, туслах аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Эрүүл хоол хүнсээр хангах, хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг сайжруулах нөхцлийг бүрдүүлнэ.
9.9. Цэцэрлэг, сургуулийн дутагдаж байгаа мэргэжлээр орон нутагт шилжин ажиллах багш нарт дэмжлэг үзүүлэх	Мэргэжлийн багшаар хангагдсан байна.
9.10. Мэргэжлийн болон Техникийн Боловсролын Сургалтын байгууллагын элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хамтран ажиллах	Мэргэжилтэй ажилтны тоо нэмэгдэнэ. Хөдөлмөр эрхэлтийг 5 хувиар нэмэгдүүлнэ.
9.11. "Үндэсний бичигтэн 2022-2024" хөдөлгөөнийг өрнүүлэх, үр дүнг тооцох	Төрийн албан хаагч болон 6-12 дугаар ангийн сурагчдыг үндэсний бичиг үсгийн мэдлэг, чадвар дээшилсэн байна.

<p>9.12.Олон улсын -"Эко сургууль, цэцэрлэг"-ийн хөтөлбөрт хамрагдах, Тусгай хэрэгцээт боловсролын төлөөх үйл ажиллагааг санхүүжүүлэн хамтран ажиллах</p>	<p>1."Эко сургууль, цэцэрлэг"-ийн сургалтад хамрагдан, ТХБ-ын төлөөх үйл ажиллагааг зохион байгуулахдаа сургууль, цэцэрлэг бүхлээрээ ажиллах арга хандлагад суралцан "Эко сургууль, цэцэрлэг"-ийн хүрэл, мөнгө, ногоон тугийн болзлыг ахиулан тогтмол ажилласан байна. 2.Нутгийн иргэдийн Тусгай хэрэгцээт боловсролын мэдлэг, хандлагыг өөрчлөх сургалтуудыг зохион байгуулсан байна.</p>
<p>9.13."Хөдөлмөр амралтын зуслан" байгуулах, сургууль, цэцэрлэг туршилтын болон ногооны талбай, хүлэмжид төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалж, хүүхдийн хоол хүнсэнд ашиглахад хамтран ажиллах</p>	<p>Сургууль, цэцэрлэгийн эзэмшил талбайд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалж, хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэсэн байна.</p>
<p>9.14.Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн гар, шүд угаах орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, "Эрүүл шүд арга хэмжээ"-ний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах</p>	<p>Гар, шүдээ угааж хэвших орчин бүрдсэнээр хүүхэд гар, шүдээ угаах дадал хэвшилтэй болоход хувь нэмэр оруулсан байна.</p>
<p>9.15.Сургууль, цэцэрлэг, дотуур байрны сургалтын таатай орчныг бүрдүүлэх, хүүхдийн хоол хүнс, эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлыг стандартад нийцүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p>	<p>Сургууль, цэцэрлэг, дотуур байр хоол хүнс, эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын стандартад нийцсэн, чанартай боловсрол эзэмших таатай орчин, нөхцөлийг бүрдүүлсэн байна.</p>
<p>9.16.Сурагчдыг цахим хичээлд хамрагдах боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах</p>	<p>"Eduten", "pearson" хөтөлбөрөөр хичээллэх цахим танхим, ахлах сурагчид сонгох хичээлд цахимаар хамрагдах боломжтой болсон байна.</p>
<p>9.17.Насан туршийн суралцахуйн төвийн бүтэц, орон тоонд нийцүүлэн төсвийг баталж, санхүүжүүлэх, хамтран ажиллах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>Боловсролын Ерөнхий Хуулийн 31.1.5 дахь заалт хэрэгжинэ.</p>
<p>9.18.Орон нутаг дахь сургалтын байгууллагуудынхаа гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг ахиулах чиглэлээр хамтран ажиллах</p>	<p>Боловсролын Ерөнхий Хуулийн 31.1.6 дахь заалт хэрэгжинэ.</p>
<p>9.19.Өвөлжилт хүндэрсэн болон байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас /салхи шуурга, хөлдөлт/ боловсролын байгууллагад үүссэн хохирлыг даван туулахад дэмжлэг үзүүлэх</p>	<p>Боловсролын үйлчилгээг хэвийн, тасалдалгүй явуулах орчныг бүрдүүлэх боломжтой болно.</p>
<p>9.20.Инноваци шингэсэн бүтээл, судалгааны ажил, эрдэм шинжилгээний шилдэг бүтээл, багш, суралцагчдын шинжлэх ухаанч сэтгэлгээ, авьяасыг хөгжүүлэх, судлаач, бүтээлч, оюунлаг иргэдийн шинэ санал, санаачилгыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг дэмжих</p>	<p>Сум, орон нутагтаа шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх боломж бүрдэнэ.</p>

Ерөө сумын Засаг даргын
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №10



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
10.1.Аймгаас зохион байгуулж буй спортын тэмцээн, нийтийн биеийн тамирын арга хэмжээний нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцох тамирчдыг сахилга баттай, ариун цэврийн стандартыг сахиж уламжлалт мэндлэх, хүндлэх, талархах, хүлээцтэй хандах ёсыг баримтлуулахад анхаарах	Тамирчны ёс зүй болон оролцож буй тэмцээний дүрэм журам, стандартыг сахин мөрдөж ажилласан байна.
10.2.Биеийн тамирын арга зүйч ажиллуулах	Арга зүйч ажиллуулсан байна
10.3.Спорт цогцолборын тоног төхөөрөмж, техник хэрэгслийг тогтмол нэмэгдүүлэх	Биеийн тамир, спортоор хичээллэх таатай боломж бүрдсэн байна.
10.4.Нийтийн биеийн тамир, спортыг иргэдийн эрүүл мэнд, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлж иргэдийн дунд спортын олон төрөлт тэмцээнийг зохион байгуулан спортын арга хэмжээнд хамрагдагчдын тоог нэмэгдүүлсэн байна	Иргэдийн дунд спортын олон төрөлт тэмцээнийг зохион байгуулж, эрүүл мэнд, идэвхтэй амьдралын хэв маягт дадал эзэмшүүлсэн байна.
10.5.Сургуулиудад хичээлээс гадуурх спортын дугуйлан секцийг хичээллүүлж, секц сургалтын тоо, хамрах хүрээг нэмэгдүүлэх	Хичээлээс гадуурх сонгон, секц дугуйлангийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж, хүүхдэд чиглэсэн сургалт, хөгжүүлэх ажлыг эрчимжүүлсэн байна.
10.6.Иргэдийг бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамруулах	Бие бялдрын түвшин тогтоох сорилыг сумын хэмжээнд зохион байгуулж иргэдийг бүрэн хамруулсан байна.
10.7.Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдаас А,В,С үнэлгээтэй иргэдийн тоог нэмэгдүүлэх	Эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг даван туулах бие, сэтгэлийн тэсвэр хатуужилтай иргэнийг бэлтгэсэн байна.
10.8.Багийн, өвлийн, үндэсний спортын төрлүүдийг хөгжүүлэх, өвлөн уламжлуулах, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	Орон нутагтаа 2-3 төрлийн арга хэмжээг зохион байгуулсан байна.
10.9.Орон нутгийн алдартай тамирчин, дасгалжуулагчдаар ёс зүй, зөв хандлага төлөвшүүлэх, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг бий болгох талаар нийгэмд зөв зүйтэй үлгэр дуурайлал болох нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна.
10.10.“Спортлог Сэлэнгэчүүд” арга хэмжээг хэрэгжүүлэх	Шалгуур үзүүлэлтийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Ерөө сумын Засаг даргын
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №11

МЦА0005 9055053

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
11.1 Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр	
11.1.1.Засгийн газрын 2023 оны 321 дүгээр тогтоолоор батлагдсан "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх" болон "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах" зорилгоор нийтийг хамарсан арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өргөнөөр татан оролцуулах үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах	"Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх" болон "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах" чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулсан байна.
11.1.2.Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг өөрийн орон нутгийн онцлогт тулгуурлан зохион байгуулах	Үзлэгийг хамрагдалтыг нэмэгдүүлж, өвчлөлийн 90 хувийг эмчилж эрүүлжүүлсэн байна.
11.1.3.Хэрэгжилтийн хугацаа дуусч буй ("Эрүүл идэвхтэй амьдрал", "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Хавдрын эсрэг", "Харшлаас сэргийлэх", "Эрүүл чийрэг эр хүн", "Элэг бүтэн Монгол", "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх", "Орчны эрүүл мэнд") хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилтийг 100 хувьд хүргэнэ.
11.1.4.Цар тахлын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэвийн, тасралтгүй байдлыг хангаж, нөөцийг бүрдүүлэн, хэнийг ч орхигдуулахгүй ажиллах	Эмнэлгийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж, нөөц бүрдүүлсэн байна.
11.1.5.Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-т өвчнийг тандах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтод бүлгийн иргэдийг хамруулсан байх	Зорилтод бүлгийн иргэдийг сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар өвчний урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулсан байна.
11.1.6.Сэтгэцийн эрүүл мэнд ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, түүний талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх болон осол, гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, автотээврийн гэх мэт)-д салбар дундын хамтын ажиллагааг ханган хамтран ажиллах	Салбар дундын хамтын ажиллагаа сайжирч, иргэд халдварт бус өвчний мэдлэг хандлага сайжирсан байна.
11.1.7.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэн эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчны тохижилт (тэргэнцэрт зориулсан үүдний хэсэг, хананы бариул, дуугүй хөтөч, тусгайлсан жорлон, дуут дохио гэх мэт)-ыг сайжруулах	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд эзлтэй орчныг бүрдүүлж, хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна.
11.2 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр	

11.2.1.“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартыг эрүүл мэндийн байгууллага бүр хэвшүүлэх	“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартыг эрүүл мэндийн байгууллага бүр хэвшүүлэн сурталчлан ажилласан байна.
11.2.2.Алслагдсан сум, багийн иргэд, малчид тариаланчдад нарийн мэргэжлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулан гэрийн эргэлт, хяналтын үзлэгийг өргөжүүлэн тусламж үйлчилгээг үзүүлэх	Иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдахгүй авч өвчнөөс шаардлагатай тохиолдолд эмчлэгдэж эрүүлжсэн байна.
11.2.3.Орон нутагт түр оршин суугч, явуулын иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэх	Иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлсэн байна.
11.2.4.Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэн жирэмсэн үеийн гурвалсан халдвар өвчний тохиолдол гаргахгүй ажиллах. Мөн тухайн сум, тосгоны малчин өрхийн жирэмсэн эмэгтэй, отор нүүдэл болон түр оршин суугаа явуулын жирэмсэн эмэгтэйчүүдийг давхар хянах	Жирэмсний эрт үеийн хяналт улс, аймгийн дунджаас дээгүүр байж жирэмсэн үеийн гурвалсан халдвар өвчний тохиолдол гаргахгүй ажиллаж эхийн ноцтой хүндрэл, амьгүй төрөлт, дутуу төрөлт буурсан байна.
11.2.5.Эх, нялхсын эрүүл мэндийг сайжруулж, өвчлөл, эндэгдлийг бууруулах ажлыг эрчимжүүлэн, үр дүнг тооцож ажиллах	0-5 хүртэлх насны хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулсан байна. Эхийн эндэгдэлгүй байна.
11.2.6.Өрх, сумын эрүүл мэндийн төвд 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг тогтмол зохион байгуулах	Хөгжлийн цогц үзлэгт 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдүүдийг бүрэн хамруулна.
11.2.7.Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл гарч зайлшгүй тээвэрлэх шаардлага үүссэн тохиолдолд онгоц болон бусад тээврийн хэрэгслийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган дэмжлэг үзүүлсэн байх	Зайлшгүй зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс дэмжлэг үзүүлсэн байна.
11.2.8.Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт өөрийн харьяа нутаг дэвсгэр дэх хүн амыг насны бүлгээр бүрэн хамруулах, энэ чиглэлд ажил олгогчид болон салбар дундын хамтын ажиллагааг ханган манлайлж ажиллах	Иргэд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж, өвчлөлийг эрт үед нь илрүүлж, эмчилгээ хяналтад хамрагдсан байна.
11.2.9.Хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдвар бус өвчин (элэг, хөх, умайн хүзүүний хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт зэрэг)-ний эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд иргэн бүрийг хамруулах, иргэдэд өгөх мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэн салбар хоорондын уялдааг ханган ажиллах	Эрт илрүүлэг үзлэг, оношилгоо хийгдэж, иргэдийн мэдлэг, хандлага сайжирсан байна. Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгэд хамрагдсан 18 -аас дээш насны хүн амын 70%-иас дээш хувийг хамруулсан байна. Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлгэд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын 95,3%-ийг хамруулсан байна. Хөх, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийг 100% хамруулсан байна.
11.3 Хүний нөөцийг хангах чиглэлээр	
11.3.1.Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр орон сууц,	Нийгмийн баталгаа сайжирч орон нутагт тогтвор суурьшилтай ажиллагчдын тоо нэмэгдсэн байна

гэрээр хангах, малжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх	
11.3.2.Дутагдалтай эмч, мэргэжилтнээр бүрэн хангаж, мэргэшил олгох болон дээшлүүлэн сургах зардлыг шийдвэрлэх, урамшуулах, эмнэлгийн мэргэжилтнийг дээд шатлалын эмнэлэгт ажлын байранд дадлагажуулан сургах, сэлгэн ажиллуулах арга хэмжээг дэмжиж ажиллах	Дутагдалтай эмч мэргэжилтнээр хангаж ажилласан байна.
11.4 Эрүүл мэндийн даатгалын чиглэлээр хийх ажил, арга хэмжээнүүд	
11.4.1.Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэдийг бүрэн хамруулах, энэ чиглэлээр орон нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллах, эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл, сурталчилгааг тогтмол хийж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай авах нөхцөлийг бүрдүүлж ажиллах	Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж зорилтот бүлгийн иргэдийг хамруулах ажлыг эрчимжүүлж, эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл, сурталчилгааг тогтмол хийж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
11.5 Бусад үйл ажиллагааны чиглэлээр	
11.5.1.Сумын ундны усны усны эх үүсвэрийн онцгой, энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавих	Хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлнэ.
11.5.2.Харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл ахуй, стандартыг хангасан ундны усаар тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг авч хэрэгжүүлж ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх	Хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлнэ.
11.5.3.Хүн амын хэрэглэж байгаа ундны болон ахуйн усны чанар, аюулгүй байдалд тухайн нутаг дэвсгэрийн төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамж хариуцсан байгууллага, албан тушаалтан холбогдох стандарт, дүрмийн дагуу хяналт, шинжилгээ хийж, усны чанарыг сайжруулах арга хэмжээг авах	Халдварт өвчин гарах эрсдэлийг бууруулна.
11.5.4.Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээг тогтмол хийлгэх, гарсан үнэлгээний дагуу арга хэмжээг авах	Хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлнэ.
11.5.5.Ахуйн гаралтай хог хаягдал, эмнэлгийн гаралтай хог хаягдлыг булшлах газарт тухайн сумын ИТХ-аар хэлэлцүүлэх газрыг олгож, Засаг дарга захирамж гаргаж баталгаажуулан хүн, мал, амьтанд халдвар тараах, байгаль орчинд аюултай хог хаягдлыг эрүүл ахуйн нөхцөл, шаардлагын дагуу цуглуулах, хадгалах, тээвэрлэх, тогтоосон тусгай цэгт булшлах	Хөрсний бохирдол буурна.
11.5.6.Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хориглосон газар, цэг болон нийтийн эзэмшлийн зам, талбайд хүнсний бүтээгдэхүүнийг ил задгай худалдаалах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлүүлэхгүй байх	Хоол хүнсээр дамжих хордлого, халдвар гарах эрсдэл буурна.
11.5.7.Эрүүл мэндийн байгууллагыг цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр ханган, цахилгаан	Цахилгааны нөөц үүсвэрийн бэлэн байдлыг ханган ажилласан байна.

эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлж дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц үүсвэрийн бэлэн байдлыг хангах


___оОо___

Ерөө сумын Засаг дарга
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №12

СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ 9055053

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
12.1.Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах талаар дэмжлэг үзүүлэх	Мэргэжлийн хүний нөөцийг өмнөх оноос 5-аас доошгүй хувиар нээгдүүлсэн байна. Соёлын ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.
12.2.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалтын дэглэм тогтоож, дурсгал нэг бүрээр кадастарт оруулах	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалт сайжирсан байна.
12.3."Удам угсаагаа дээдэлж, угийн бичгээ хөтөлө" жилийн аяныг зохион байгуулах	Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сургалтын байгууллагатай хамтран 2 удаа сургалт зохион байгуулж, нийт өрхийн 20 хувийг хамруулж, угийн бичгийг хөтлөх ажлыг эрчимжүүлнэ.
12.4.Соёл, урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, түүх, соёлын дурсгалт зүйлсийг гэрээгээр хариуцагчдыг бодлогоор дэмжих	Багийн Засаг дарга нартай хамтран гурвалсан гэрээ байгуулж хариуцуулах, хууль бус малтлага гаргахгүй байх ажлыг зохион байгуулсан.
12.5.Нүүдэлчин ахуй, үндэсний өв, соёл, уламжлалыг сурталчилан таниулах "Би Монгол хүүхэд" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	Үндэсний өв, соёл, уламжлалаа дээдэлсэн Монгол хүнийг төлөвшүүлэх үндэсний агуулгатай 3-аас доошгүй контент бүтээсэн байна.
12.6. Бүх нийтэд соёлын боловсрол олгох олон талт үйл ажиллагааг зохион байгуулах	Бүх нийтэд соёлын боловсрол олгох хөтөлбөрийн тоо нэмэгдсэн байна.
12.7."Номын баяр-2024" арга хэмжээг зохион байгуулж, номын сангийн сан хөмрөгийн баяжилт хийхэд дэмжлэг үзүүлэх.	Ном уншлагыг дэмжиж, номын сангийн сан хөмрөг, уншигчдын тоог нэмэгдүүлсэн байна.
12.8.Тусгай хэрэгцээт иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	6-гаас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.
12.9.Үндэсний бичиг соёлын өвийг сурталчилах, "Бүх нийтээр хос бичигтэн" болоход уриалсан нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах	Үндэсний бичиг соёлын өвийг сурталчилсан олон талт арга хэмжээний тоо нэмэгдсэн байна.
12.10.Соёлын биет болон биет бус өвийг өвлөн уламжлагчийг батламжилж, шавь сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	Соёлын биет болон биет бус өвлөн уламжлагчийн бүртгэлийг нэмэгдүүлж, тэднийг сурталчилан таниулах 6-аас доошгүй арга хэмжээг зохион байгуулсан байна.
12.11.Олон улс, улсын чанартай уралдаан тэмцээнд оролцох ардын авъяастан, хүүхэд багачуудад дэмжлэг үзүүлэх	30-аас доошгүй ардын авъяастан, хүүхэд залуучуудыг дэмжсэн байна.
12.12.Соёл, урлагийн байгууллагуудын тохижилтын засвар хийх, хөгжим техник хэрэгслийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх	Тоног төхөөрөмжийн судалгаа гаргах, тохижилт, урсгал засварыг үе шаттай хийж ажиллах нөхцөлийг сайжруулсан байна.

<p>12.13.Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Соёл, урлагийн газрын даргын хамтарсан 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/242, А/76 тоот тушаалаар батлагдсан “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах журам”-ыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах</p>	<p>Журмын хэрэгжилтийг хангаж хүүхдийг болзошгүй аюул эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэгдсэн байна.</p>
<p>12.14.Түүх соёлын дурсгалт газар болон байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн соёлын аялал жуулчлалын маршрут гаргаж явган аялал болон эвент зохион байгуулах</p>	<p>Явган аялал болон эвент арга хэмжээгээр дамжуулж дотоод болон гадаад аялагчдын тоо өссөн байна</p>
<p>12.15. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн зураглал, төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах</p>	<p>Орон нутгийн соёлын бүтээлч үйлдвэрлэл, брэнд, бүтээгдэхүүн, эвент арга хэмжээг зохион байгуулж хөгжүүлсэн байна.</p>



Ерөө сумын Засаг даргын
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №13

ХҮН АМ ЗҮЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
13.1.Өрхийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, цус ойртолтыг багасгах арга хэмжээ /хөтөлбөр/-г хэрэгжүүлж, мэргэжлийн байгууллагаас угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөөг авах, багш ажиллуулж иргэдийн угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлэх	Угийн бичиг хөтлөх арга зүйн 5 сургалт зохион байгуулж, угийн бичиг хөтөлдөг өрхийг 10-аар нэмэгдүүлсэн байна.
13.2.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18.1.2 заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг 2 удаа хэлэлцэнэ.
13.3.Хамтарсан багийн үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр хангаж, зардлыг орон нутгийн төсөвт тусган иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Сумдын Засаг дарга Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлж, арга зүйгээр ханган ажиллана.
13.4.Хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлж, зорилтот өрх, гэр бүл, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг судлан тогтоож, хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, шаардлагатай тусламж үйлчилгээнд хамруулах	Зорилтот гэр бүл, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдэд жилд 2 удаа эрсдэлийн үнэлгээ хийж, үйлчилгээ шаардлагатай өрх, гэр бүл, хүүхдэд хамгааллын үйлчилгээ 100 хувь үзүүлсэн байна.
13.5.Хүүхдийн хамгаалал, залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр аж ахуй нэгж, байгууллагаас гаргаж буй санал санаачлагыг хөхүүлэн дэмжиж, хамтран ажиллах	Хүүхдийн элч, залуучуудын элчтэй хамтран хүүхэд хамгаалал, залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр 4 арга хэмжээг зохион байгуулсан байна.
13.6.Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, хурдан морь уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах	Хориглосон хугацаанд нутаг дэвсгэрийн хэмжээнд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахгүй байх, Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.
13.7.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулж, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлэх	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байх,Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн хуралдааныг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг хангасан байна.
13.8.Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	2 аян, 10 сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулна.
13.9.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоол "Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад эцэг эхийн зөвлөл байгуулж гэр бүлийг дэмжсэн хөтөлбөр	Гэр бүлийг дэмжсэн хөтөлбөр баталж, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад эцэг эхийн зөвлөл байгуулж ажилласан байна.

хэрэгжүүлэх	
13.10.Хүүхдийн тусламжийн 108 утаснаас шилжүүлсэн хүүхэд хамгааллын дуудлагыг шуурхай шийдвэрлэж кейс менежментийн үйлчилгээ чанартай хүргэх	Кейс шийдвэрлэлтийг 100 хувьд хүргэсэн байна.
13.11.Хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлж, зорилтот өрх, гэр бүл, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийг судлан тогтоож аюулгүй байдлыг хангах, орон нутгийн хэмжээнд хяналтын камер байршуулах, шаардлагатай тусламж үйлчилгээнд хамруулна	Жилд 2 удаа эрсдэлийн судалгааг хийж, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийн аюулгүй байдлын хангаж, 2 арга хэмжээ, төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлсэн байна.
13.12.Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хэрэгжилтийг ханган ажиллах	Дэмжлэг шаардлагатай ахмад настанд дэмжлэг үзүүлсэн байх
13.13.“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангах ажиллах, шаардлагатай хөрөнгийг төсөвт тусгах	“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийг байгуулж, төсвийг шийдвэрлэн, дэмжлэг үзүүлсэн байна.
13.14.Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, эрхийг хангах хүрээнд сонгуулийн санал авах байрыг хүртээмжтэй болгох, тэдний улс төрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чигэлсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	Сонгууль авах байрыг хүртээмжтэй болгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх 1 сургалт зохион байгуулсан байна.
13.15.Бага насны хүүхдийн цахим донтолтоос урьдчилан сэргийлж, цахим орчинд хүүхэд хамгаалахад чиглэсэн нөлөөллийн ажил, арга хэмжээ, зохион байгуулсан байна.	4 аян, 6 арга хэмжээ зохион байгуулсан байна.
13.16.Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	5 удаа сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулсан байна.
13.17.Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлыг эрчимжүүлж, улирал тутам хувиариарийн дагуу мэдээллийг тайлагнах / цахимаар/	Сум тус бүр хувиариарийн дагуу мэдээллийг тайлагнасан байх / Аймгийн Засаг даргын зөвлөлд цахимаар танилцуулах/

Ерөө сумын Засаг даргын
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №14

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАЛАМЖ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ**

Арга хэмжээ	Хүрэх үр дүн
14.1. Хөдөлмөр эрхлэлт	
14.1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажлын байр нэмэгдүүлэх, хадгалах, тогтвор суурьшилтай ажиллах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг төр, хувийн хэвшил болон тусгай сангуудын эх үүсвэрээр шинээр байнгын ажлын байр бий болгон бүртгэж, мэдээлэх	Хөдөлмөрлөх, орлого олох боломжийг нь бүрдүүлсэн байна.
14.1.2. Зорилтот бүлгийн өрх, иргэнд дэмжлэг үзүүлэх зэргээр ажил хөдөлмөр эрхлэх, тогтмол орлого олох боломжийг бүх талаар дэмжин ажиллах	Байнгын ажлын байр бий болсон байна.
14.1.3. Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем Ejob платформыг тухайн орон нутгийн ажил олгогч, ажил хайгч, иргэд, олон нийтэд танилцуулж сурталчилах	Ejob платформыг тухайн орон нутгийн ажил олгогч, ажил хайгч, иргэд, олон нийтэд танилцуулж сурталчилсан байна.
14.1.4. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан өрхийн хөдөлмөрийн насны ажил хөдөлмөр эрхлэх боломжтой иргэдийг ажилд зуучлан ажлын байраар хангаж, өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс түтгэлзүүлэх ажлыг зохион байгуулах	Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа өрх иргэдийн тоо буурсан байна.
14.1.5. Аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд сурталчлах "ХАБЭА-н сарын аян-2024" арга хэмжээг зохион байгуулах	Иргэд, албан хаагчдын ойлголт, мэдлэг нэмэгдсэн байна.
14.1.6. Бүх аж ахуйн нэгж байгууллагууд, ажил олгогчдод хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг жигд хангуулан ажиллах, сургалт, сурталчилгааны ажлыг нийтийг хамруулан зохион байгуулж, ажил олгогч, ажилтан, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд эрүүл, аюулгүй ажиллах талаар аяныг өрнүүлэн ажиллах	Бүх аж ахуйн нэгж байгууллагууд, ажил олгогчдод аюулгүй ажиллах талаар аяныг өрнүүлэн ажилласан байна.
14.1.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн, тэдний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг аливаа сургалт нөлөөллийн ажил, хэлэлцүүлэгт хамруулж, саналыг нь сонсох замаар тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэгш боломжийг хангасан байна.
14.2. Нийгмийн хамгаалал	
14.2.1. Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох шинэчилсэн аргачлалын дагуу харьяа нутаг дэвсгэрийн зорилтот өрх, иргэнийг тодорхойлоход Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүх талын дэмжлэг, туслалцааг үзүүлж хамтран ажиллана	Дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна.
14.2.2. Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийг хэвийн, хараат бусаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах	Амьжиргааг дэмжих зөвлөлийг хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байна.
14.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилладаг Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хөнгөлөлт, тусламж болон

		үйлчилгээ үзүүлж буй төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлсэн байна.
14.2.4.Ахмад настны хөгжил, оролцоог хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх		Ахмад настны тухай хууль тогтоомжид заасан үйлчилгээ, хөнгөлөлтийг олгох ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжин ажилласан байна.
14.3.Нийгмийн даатгал		
14.3.1.Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлж ажиллах	9,141,980.75 мянган төгрөгийн орлого бүрдсэн байна.	Үүнээс: Бугант тосгон 908,968.86 мянган төгрөгийн шимтгэлийн орлого бүрдсэн байна
14.3.2.Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлж ажиллах	2,341,653.4 мянган төгрөгийн орлого бүрдсэн байна.	Үүнээс: Бугант тосгон 180,736.7 мянган төгрөгийн орлого бүрдсэн байна.
14.3.3.Шимтгэл төлөгч ажил олгогчдын тоог нэмэгдүүлэх	3 ажил олгогчийг нийгмийн даатгалд хамруулсан байна.	Үүнээс: Бугант тосгон 4 ажил олгогчийг нийгмийн даатгалд хамруулсан байна.
14.3.4.Албан журмын даатгалд даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх	38 даатгуулагч албан журмын даатгалд хамрагдсан байна.	Үүнээс: Бугант тосгон 13 даатгуулагч албан журмын даатгалд хамрагдсан байна.
14.3.5.Сайн дурын даатгалд даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх	29 даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдсан байна.	Үүнээс: Бугант тосгон 13 даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдсан байна.
14.3.6.Сайн дурын даатгалд хамруулах малчдын тоог нэмэгдүүлэх	9 малчдыг сайн дурын даатгалд хамруулсан байна.	Үүнээс: Бугант тосгон 1 малчдыг сайн дурын даатгалд хамруулсан байна.
14.3.7.Шимтгэлийн хуримтлагдсан өр авлагыг 30-аас доошгүй хувиар бууруулах	Өр авлага 17,311.42 мянган төгрөгөөр бууруулсан байна.	Үүнээс: Бугант тосгон 22,266.74 мянган төгрөгөөр бууруулсан байна.
14.3.8.Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх	Өр үүсгэхгүй ажилласан байна.	
14.3.9.Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулах	Иргэдийн хууль тогтоомжийн мэдлэг дээшилсэн байна.	

Ерөө сумын Засаг даргын
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №15

ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮГИЙН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

М:ОА0005 9055053

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
15.1.Санхүү, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан заавар журмыг үндэслэн өөрийн харьяа нутаг дэвсгэрт арга зүй, зохион байгуулалтын шуурхай удирдлагаар хангаж, үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцна	Орон нутгийн төсөв, санхүүгийн бодлого төлөвлөлтөөс эхлэн сайжирна, төсвийг зохистой удирдана.
15.2.Аймгийн Засаг даргын баталсан сар, улирлын хуваарилалтыг үндэслэн сумын төсвийн байгууллагын сар, улирлын хуваарилалтыг батлан мөрдөж ажиллана. Орон нутгийн болон улсын төсвийн байгууллагуудын санхүүжилтийг сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу сумын төрийн сангийн дансаар дамжуулан гүйцэтгэх	Төсвийн сар, улирлын хуваарь зохистой хуваарилагдан, төсвийн байгууллагуудад чирэгдэлгүй түргэн, шуурхай үйлчилгээг хүргэн, иргэдэд үйлчлэх төсвийн байгууллагын үйл ажиллагаа сайжирна.
15.3.Төсвийг хэмнэлттэй зарцуулах тухай Засгийн газраас баримталж буй бодлого шийдвэрийг санхүү, төсвийн үйл ажиллагаандаа шуурхай, зөв зохистой хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах	Төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах хяналт нэмэгдэнэ.
15.4.Төсвийн байгууллагуудын олон жилийн насжилттай өр, авлагыг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлж, өр авлагагүй ажиллах бүхий л арга хэмжээг авч ажиллах	Төсвийг зохистой удирдан өр, авлагагүй ажиллана, бууруулна.
15.5.Аудит болон хяналт шалгалтын байгууллагуудаас хийгдсэн шалгалтын зөрчил дутагдлыг арилгаж, цаашид давтан алдаа дутагдал гаргахгүй ажиллах	Санхүүгийн алдаа зөрчил буурна, сахилга бат сайжирна, хяналт шалгалтын зөвлөмжийн үр дүн дээшилнэ.
15.6.Аймаг, сумын төсвийн орлогын бүрдүүлэлтэд хяналт тавин улсын болон аймгийн төсвийн орлогыг хуваарийн дагуу бүрэн төвлөрүүлэх	Төсвийн орлогын төлөвлөгөөг бүрэн төвлөрүүлсэнээр аймаг сумын төсөв, санхүүгийн байдал сайжран, төр төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа тасралтгүй хэвийн явагдана.
15.7.Аймаг, сумын төсвийн төслийг боловсруулахдаа Төсвийн тухай хуулийн дагуу иргэд, олон нийтийн оролцоог хангасан байх, хөтөлбөрт суурилсан төсвийн төслийг хуулийн хугацаанд Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлэн хянуулах	Иргэдийн төсвийн шууд оролцоо нэмэгдэж, төсвийн төлөвлөлтийг бодитой төлөвлөсөн байна.
15.8.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг батлахдаа Төсвийн тухай хуулийн 60.3 дахь заалтыг үндэслэн иргэдийн оролцоог хангаж, сангийн хөрөнгийн зориулалтын дагуу зарцуулж, сар бүр Орон нутгийн хөгжлийн сангийн програмд төлөвлөлт, зарцуулалтын талаарх үнэн зөв мэдээг оруулан тус сангийн үйл ажиллагаанд иргэд, олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэн ажиллах.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний зарцуулалтыг улирал бүр иргэд, олон нийтэд ил тод тайлагнадаг болно.
15.9.Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системийн мэдээллийн аюулгүй байдал, нууцлал, найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах	Төрийн сангийн үйл ажиллагаа хэвийн явагдана.

15.10.Төсөв болон төсвийн гүйцэтгэлийн сар, улирлын мэдээ тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарын дагуу гаргаж иргэд олон нийтэд мэдээлэн, Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлэх	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг харьяа дээд байгууллагын удирдлага болон иргэдэд цаг хугацаандаа үнэн зөв мэдээлэгдсэн байна.
15.11.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах болон шуурхай удирдлагаар хангаж ажиллах, төсөвт байгууллагын шилэн дансны мэдээллийн үнэн зөв, бодит байдалд хяналт тавин ажиллах	Шилэн дансны хууль хэрэгжиж, төсвийн мэдээлэл ил тод нээлттэй мэдээлэгдсэн байна.
15.12.Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын дагуу нөөц хөрөнгийг зарцуулж, тайлагнан ажиллах	Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын тайлагналт үнэн зөв мэдээлэгдэнэ.
15.13.Төрийн сангийн үйл ажиллагааны журам, төрийн сангийн үйл ажиллагаанд хийх дотоод хяналтын журмыг хэрэгжүүлэхэд анхаарч, сумдын санхүүгийн албаны ажилтнуудад мөрдүүлж, хариуцлагыг дээшлүүлж ажиллах	Төрийн сангийн үйл ажиллагаа сайжирна.
15.14.Санхүү, төрийн сангийн хэлтсээс явуулсан хугацаатай албан бичиг болон, албан даалгаврын биелэлтийг цаг хугацаанд нь ирүүлэх	Хариуцлага сайжирч, хамтын ажиллагааны уялдаа холбоо сайжирна.
15.15.Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журмыг мөрдөн сумын Санхүүгийн албаны даргыг аймгийн Засаг даргатай, төсвийн байгууллагуудын нягтлан бодогчийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргатай тус тус зөвшилцөн томилж, чөлөөлөх болон Санхүүгийн албаны боловсон хүчний тогтвортой ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллах	Санхүүгийн алба тогтвортой ажиллах нөхцөл боломж бүрдэж, санхүүгийн сахилга, хариуцлага дээшилж, төрийн сангийн тогтолцоо бэхжинэ.
15.16.Нягтлан бодох бүртгэлийн хуулийн хүрээнд аж, ахуйн нэгж байгууллагуудын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хэрэгжилтийн байдалд зөвөлгөө өгөх, Нягтлан бодох бүртгэлийн хууль, Аудитын тухай хууль болон холбогдох заавар журмыг сурталчлах, аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн тайлан хуулийн хугацаанд нэгтгэгдэж байгаа байдалд холбогдох санхүүгийн тайлангийн нэгтгэлийн програмаар дамжуулан хяналт тавих	Нягтлан бодох бүртгэлийн хуулийн хэрэгжилт хангагдаж, аж ахуйн нэгжийн бүртгэл сайжирна.

Ерөө сумын Засаг даргын
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №16



СТАТИСТИКИЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
16.1.2024 оны сумдаас нэгтгэж ирүүлэх албан ёсны статистикийн 42 төрлийн мэдээг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж гаргаж, аймгийн Статистикийн хэлтэст ирүүлэх	Албан ёсны статистикийн мэдээг Статистикийн хэлтэс хугацаанд нь хүлээн авсан байх бөгөөд боловсруулалт хийгдэж, үр дүнг хэрэглэгчдэд тархаасан байна.
16.2.Албан ёсны статистик мэдээ, тайлан, тооллого, судалгааны баталгаажуулалт, үнэн бодит байдал, чанар, хүртээмжийг дээшлүүлэх	Албан ёсны статистик мэдээ, тайлан баталгаажсан, үнэн зөв, бодит байдал сайжирсан байна. Сумдын төр, төсвийн байгууллагуудад статистик мэдээллийг тархаасан байна. Мэдээлэл хэрэглэгчдийн статистик мэдээллийн талаарх ойлголт сайжирч, хэрэгцээтэй мэдээллээр хангагдсан байна.
16.3.Аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн "Анхан шатны статистик мэдээ тайлангийн чанар, үр нөлөөг сайжруулах тухай" 05 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх	Анхан шатны статистик мэдээ, тайлан хугацаа хоцрогдолгүй, алдаагүй, чанартай гарсан байна. Баг, сумын түвшинд нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийн чанар сайжирч, хүртээмж дээшилсэн байна.
16.4.Хүн ам, өрхийн мэдээллийн онлайн сан дээр өрх, иргэний бүртгэл, мэдээлэл, хөдөлгөөн өөрчлөлтийг багийн Засаг дарга нараар цаг тухай бүрт нь хөтлүүлж, мэдээллийн санг баяжуулсан байх	Баг тус бүр дээр хүн ам, өрхийн дэлгэрэнгүй бүртгэл тогтмол хөтлөгдөж, аймаг, сум, багийн удирдлагын түвшинд ашиглах хүн, ам өрхөд суурилсан нийгэм, эдийн засгийн байнгын мэдээллийн сантай байна. Сар бүрийн Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа чанартай явагдаж, нөөц өрхийн мэдээлэл ороогүй байна.
16.5.Өрхөд суурилсан "Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа", "Ажиллах хүчний судалгаа", болон бусад судалгааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, удирдлага, зохион байгуулалтаар хангах /сонгогдсон багт хөтөч ажиллуулах/	Судалгаанууд чанартай, үр дүнтэй зохион байгуулагдаж, судалгааны бүхий л мэдээллийг ҮСХ-нд хугацаанд нь дамжуулж, судалгааны үр дүнг нэгтгэх, боловсруулах, тархах бүрэн боломж хангагдсан байна.
16.6.Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн ээлжит тооллого болон бусад тооллогыг орон нутагтаа чанартай, үр дүнтэй зохион байгуулж, шаардлагатай санхүүжилт, хүн хүч, техник хэрэгслээр хангах, туслалцаа үзүүлэх	Тооллого чанартай, үр дүнтэй зохион байгуулагдаж, үр дүнг ҮСХ-нд дамжуулж, аймаг, сумын түвшинд мал тооллогын шинэчлэгдсэн мэдээллийн сан бий болсон байна.

Ерөө сумын Засаг даргын
аймгийн Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №17

**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, БАТЛАН ХАМГААЛАХ
САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ**

Ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн
17.1.Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх, таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, арилгах арга хэмжээ авч, энэ асуудлаар нутаг дэвсгэртээ байгаа үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй албадад чиглэл өгч, холбогдох байгууллагад санал, хүсэлт тавьж ажиллах;	Орон нутагт Үндэсний аюулгүй байдлын үзэл, баримтлал хангагдсан байна.
17.2.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журмын 2 дугаар бүлэгт тусгагдсан мэдээг 7 хоног бүрийн Даваа, Пүрэв гарагийн 10:00-11:00 цагийн хооронд, яаралтай болон шуурхай мэдээг тухай бүр Цэргийн штабын 7036-2570, 9411-2802 дугаарын утсаар болон selenge_tssh@mod.gov.mn цахим хаягаар ирүүлж байх;	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг орон нутгийн мэдээ, мэдээллээр хангасан байна.
17.3.Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, задрах, үрэгдэхээс урьдчилан сэргийлэх, хяналт, шалгалтыг сайжруулах;	Төрийн алба хаагч бүр хуулийн заалтыг албандаа мөрдлөг болгон ажилласнаар төрийн нууц хамгаалагдана.
17.4.Батлан хамгаалах багц хуулийг хэрэгжүүлэх, иргэдэд сурталчлах, ажлыг зохион байгуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	Иргэд хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлэх мэдлэг мэдээлэлтэй болсон байна.
17.5.Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, Зэвсэгт хүчний 103 жил, чөлөөлөх дайны 79 жил, Халх голын ялалтын 85 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах, ахмад дайчдад хүндэтгэл үзүүлэх;	Иргэн цэргийн харилцаа бэхжүүлэхэд болон хүүхэд залуус эх оронч, үндэсний үзэл төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.
17.6.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд цэрэгжилтийн спортын цогцолбор “Дөл-2024” тэмцээний эхний шатыг сумандаа зохион байгуулж шалгарсан сурагчдыг аймгийн аварга шалгаруулах тэмцээнд бэлтгэж оролцуулах;	Ахлах ангийн сурагчид “Дөл-2024” тэмцээнд оролцсон байна.
17.7.Төрийн захиргааны болон төрийн улс төрийн албан хаагчдын цэргийн бэлтгэл сургалтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабтай хамтран зохион байгуулах;	Суманд Батлан хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах чадамж нэмэгдэнэ.
17.8.Цэргийн бүртгэл явуулах, цэргийн бэлтгэл үүрэгтний тоо, чанарт дүн шинжилгээ хийх;	Мэдээнд үндэслэн сумын бэлтгэл үүрэгтний тоо, чанар, дайчилгааны даалгаврыг бүрэн биелүүлэх боломж болон бэлтгэл үүрэгтний тоо төрөл тус бүрээр өссөн, буурсан дүн гарна
17.9.Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион	Улс орноо батлан хамгаалах

байгуулах, гэрээт цэрэг элсүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэн, цэрэг татлагын байранд хүргэх болон холбогдох бусад зардлыг тухай сумын Засаг дарга хариуцах;	бэлтгэл нөөцийн боломж дээшилж, дайчилгааны бэлэн байдал хангагдана.
17.10.Сумын "Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө"-нд тодотгол хийх, сумын Батлан хамгаалах товчоо, тосгоны дайчилгаа удирдах хэсгийн шинэчлэн батлагдсан орон тооны дагуу үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг бүрэн томилгоожуулж тэдэнтэй зохион байгуулах сургалтыг Цэргийн штабтай хамтран явуулах, түүнд шаардлагатай зардлыг бүрэн хариуцах;	Дайчилгаа зарлагдсан үед үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарь, тодорхой болж бэлэн байдал хангагдсан байна.
17.11.Дайчилгаанд шаардлагатай бараа материал, хэрэгсэл, автомашин болон бусад эд зүйлсээр хангах үүрэг хүлээсэн томилгоот иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг тодотгох, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээ цуцлах арга хэмжээг авч ажиллах;	Дайчилгааны явуулах, түүнийг удирдах нөхцөл бололцоо бүрдсэн байна.
17.12.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийг сонгон авах, тэдний албаны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах;	Алба хаагч иргэдийн үйл ажиллагаанд хяналт тавьсан байна.
17.13.Цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг хуульд заасан хугацаагаар сургалтад хамруулах, тэднийг дайчилгааны командуудад оногдуулан бүртгэх;	Дайчилгааны томилгоот бүрэлдэхүүний чадавх нэмэгдсэн байна.
17.14.Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдэд мөнгөн төлбөр ногдуулж, төлөлтөд хяналт тавьж ажиллах;	Улс орноо Батлан хамгаалахад хуулиар хүлээсэн үүргээ иргэн бүр биелүүлэх нөхцөл бүрдэнэ.
17.15.Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэхэд сумын эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллах, тэдэнд дэмжлэг үзүүлэх;	Цэргийн насны залуучуудын эрүүл мэнд байдалд ахиц гарсан байна.
17.16.Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний сургалтыг үе шаттай зохион байгуулах, нөөцийг бүрдүүлэх;	Томилгоот нэгжийн бүрэлдэхүүний бэлтгэл, бэлэн байдал дээшилсэн байна.
17.17.Цэргийн бүртгэлд байгаа эрчүүдийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж бүртгэл хөтлөх;	Цэргийн үүрэгтний шилжилт хөдөлгөөнд тавих хяналт сайжирсан байна.
17.18.Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын ар гэрт дэмжлэг үзүүлэх, тэднийг халагдан ирэхэд нь хүлээн авах, суралцах болон хөдөлмөр эрхлэлт, зайлшгүй тохиолдолд амьжиргааны эх үүсвэрт орон нутгаас дэмжлэг туслалцаа үзүүлэх.	Цэргийн алба хаагчийн ар гэрт болон тэдэнд дэмжлэг үзүүлсэн байна.
17.19.Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийг шинэчлэн байгуулах, Улсын хил хамгаалах үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлэн Хилийн цэргийн анги, салбартай хамтран ажиллаж тэдгээрт ажиллаж буй алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарч ажиллах	Хил хамгаалалтад дэмжлэг үзүүлж, хилийн дэглэмийн зөрчил буурах, алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой нөлөөлөл үзүүлсэн байна. (Алтанбулаг, Ерөө, Хүдэр, Түшиг, Сүхбаатар сумдад хамааралтай)